

Баримт бичгийн нэр	“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
Гүйцэтгэгч	“Саусгоби сэндс” ХХК
Төслийн нэр	Овоот Толгой нүүрсний уурхай (MV-012726)
Огноо	2023/01/14
Төлөвлөгөө боловсруулсан	Б.Цулбаяр /Усны мэргэжилтэн/ Б.Төрбагана /Нөхөн сэргээлт Орон нутаг хариуцсан мэргэжилтэн/
Хянасан	Д.Ариунболд /Байгаль орчин, орон нутгийн харилцааны хэлтсийн менежер/
Баталсан	Шюй Жинь Шөн /Саусгоби сэндс ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал
Хүлээн авагч хуулийн этгээд	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
Хувийг	<ul style="list-style-type: none"> Өмнөговь аймгийн Гурвантэс сумын ЗДТГ

ГАРЧИГ

ГАРЧИГ	1
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн товч мэдээлэл	4
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1. Байгаль орчны төлөв байдал	6
2.1.1. Физик газарзүйн онцлог	6
2.1.2. Цаг уур, уур амьсгал	6
2.1.3. Гадаргын болон газар доорх усан сүлжээ	6
2.1.5. Хөрсөн бүрхэвч	7
2.1.6. Ургамлын аймаг	7
2.1.7. Амьтны аймаг	7
2.2. Төслийн нийгэм-эдийн засгийн төлөв байдал	7
2.2.1. Овоот Толгой төслийн байршил	7
2.2.2. Хүний нөөц	8
2.2.3. Дагалдах дэд бүтэц	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	17
3.1. Ил уурхайн нүүрс олборлох үеийн болзошгүй нөлөөлөл.....	18
3.2. Хуримтлагдах нөлөөлөл	20
3.3. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн ангилал, цар хүрээ, эрчим давтамж.....	22
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	25
3.1. Эрх зүйн үндэслэл	26
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
8.1 Төлөвлөгөөний хамрах хүрээ	33
8.2 Бүрэн хийгдсэн нүүлгэн суурьшуулалт.....	33
8.3 Нүүлгэн суурьшуулалт хийгдэх төлөвлөгөө.....	33
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
9.1 Олон нийтийн хөтөлбөр, биет бус өв	34
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
10.1 Химийн бодисын төрөл, хэмжээ	35
10.2 Химийн бодис, материалаас үүсэж болох болзошгүй эрсдэл	35
10.3 Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	37
10.4 Эрсдэл тохиолдох үед авах арга хэмжээ	38
10.5 Эрсдэл тохиолдсоны дараа авах арга хэмжээ, хяналт.....	39
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	40
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	43
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	44
14. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛИЙН ТАЛААР ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ	49

ГРАФИК

График 1. Хүний нөөцийн бүрэлдэхүүн	8
---	---

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл	5
Хүснэгт 2. Төслийн талбайн байгууламжууд	9
Хүснэгт 3. Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмж	16
Хүснэгт 4. Овоот Толгой уурхайн нөхөн сэргээлтийн мэдээлэл.....	17
Хүснэгт 5. Ил уурхайн үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь (БОНБНУ тайлангаас 2016 он).....	18
Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагаа болон бүс нутагт хэрэгжиж буй бусад төслүүдээс үүсэлтэй болзошгүй хуримтлагдах нөлөөлөл	20
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил.....	27
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах ажил.....	29
Хүснэгт 9.Нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардал	31
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалахаар санал болгож буй газар	32
Хүснэгт 11. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ.....	33
Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	34
Хүснэгт 13. Соёлын өвийг хамгаалах хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө.....	34
Хүснэгт 14. Химийн бодис, материалаас үүсэж болох болзошгүй эрсдэл.....	36
Хүснэгт 15. Эрсдэл тохиолдож болох газрууд.....	38
Хүснэгт 16. Овоот Толгой уурхайн хог хаягдлын ангилан ялгалт.....	41
Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын задргаа.....	42
Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээг гүйцэтгэх хүснэгтэн төлөвлөгөө.....	54
Хүснэгт 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтын хүрээнд 2023 онд хийгдэх ажлууд.....	52
Хүснэгт 20. Овоот Толгой уурхайн 2023 онд БОМТ түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	56

ЗУРАГ

Зураг 1. Овоот Толгой уурхайн байршил	4
Зураг 2. Овоот Толгой уурхайн Нармандах малталтын хэсэг	5
Зураг 3. Лицензийн талбайн байршил.....	8
Зураг 4. Уурхайн ажилчдын тосгон	10
Зураг 5. Засварын газар	10
Зураг 6. Шатахуун түгээх станц болон агуулах	11
Зураг 7. Дэд бүтцийн байгууламж Тэсрэх бодисын агуулах	11
Зураг 8. Гаалийн баталгаат агуулах (а. Наржаргах уурхай б. Нармандах уурхай).....	12
Зураг 9. Овоот Аэродром	12
Зураг 10. Нарийнсухайт-шивээхүрэн чиглэийн хүнд даацын концессын авто зам.....	13
Зураг 11. Бохир ус цэвэршүүлэх байгууламж	14
Зураг 12. Нүүрсийг нойтон технологиор баяжуулах үйлдвэр	15
Зураг 13. Хогийн цэг (кемп, засвар).....	15
Зураг 14. MT 4400 хүнд даацын машин Зураг 15. PV275 Тэсэлгээний өрөм, Экскаватор	17
Зураг 16. Овоот Толгой уурхайн объектийн нөлөөлөл.....	24
Зураг 17. Дүйцүүлэн хамгаалахаар санал болгож буй газар нутаг.....	32
Зураг 18. Химийн бодис, материалын хадгалалт	36




Зураг 19. Хаягдал тос, бохирдсон хөрс хураах цэвэршүүлэх талбай, зарим төрлийн хог хаягдал устгах шатаах зуух.....	36
Зураг 20. Эрсдэл тохиолдох үед авах шаардлагатай хэрэгслүүд.....	39
Зураг 21. Асгаралт үүссэн тохиолдолд хэрэглэх асгаралтай тэмцэх цэг, иж бүрдэл	39

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч мэдээлэл

Овоот Толгой нүүрсний уурхайд ашиглалт явуулж буй Саусгоби сэндс ХХК нь (улсын бүртгэлийн дугаар: 9019019096) Канад улсад төвтэй, Торонто болон Хонг-Конгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Саусгоби Ресурс Лимитед (TSX.V: SGQ, НК: 1878) нээлттэй хувьцаат компанийн Монгол дахь салбар бөгөөд Монгол улсад нүүрсний хайгуул, олборлолтоор дагнан 13 дахь жилдээ ажиллаж байна.

Овоот Толгой уурхай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэр V буюу Бага овоо багийн нутагт, Хөвхийн хөндий–Нарийн сухайтын нүүрсний орд газарт, Даланзадгад хотоос 320 км, нийслэл Улаанбаатар хотоос 950 км зайд, баруун өмнөд зүгт, Шивээ-Хүрэнгийн боомтоос 56 км-т (х.ө 42°59'619, з.у 101°16'83, өндөршил д.т.д 1526 метр) оршдог. Тусгай зөвшөөрлийн дугаар MV-012726 (9312.27 га) ба 2039.09.20-ны өдрийг дуустал тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа үйлчилж байна.



Зураг 1. Овоот Толгой уурхайн байршил

Тус компанийн олборлолт явуулж буй “Овоот Толгой” уурхайгаас хагас коксжих, дунд болон өндөр үнслэгт нүүрс олборлож байна.

Саусгоби сэндс ХХК нь Овоот Толгой нүүрсний орд газрын хайгуулын ажлаа 2005 онд эхэлж, 2007 оны 9-р сард ашиглалтын лиценз авсан бөгөөд 2008 оны 9-р сард анх нүүрс экспортолж эхэлсэн. Тус уурхай нь Баруун уурхай буюу “Наржаргах – Sunset”, Зүүн өмнөд уурхай буюу “Нармандах – Sunrise” гэсэн 2

малталтын хэсэгт ашиглалт явуулж байна. Овоот Толгой уурхайгаас дараах 3 төрлийн нүүрсийг олборлож байна. Үүнд:

- Хагас коксжих нүүрс / Үнслэг 0-10%/
- Дунд зэргийн үнслэгтэй хагас коксжих нүүрс / Үнслэг 10-15%/
- Эрчим хүчний нүүрс / Үнслэг >15%/



Зураг 2. Овоот Толгой уурхайн Нармандах малталтын хэсэг

Нүүрсийг Шивээ хүрэнгийн боомтоор БНХАУ руу экспортлох бөгөөд гол хэрэглэгч нь Хятадын Төмөрлөгийн үйлдвэрүүд юм. Уурхайн хүчин чадал нэмэгдүүлэхтэй холбогдон “Техник-эдийн засгийн үндэслэл”-ийг 2021 онд шинэчлэн боловсруулж байгаа ба нарийвчилсан хайгуулаар 345.8 сая тонн (А+В+С) нүүрсний нөөц илрүүлснээс уурхайн хил хязгаар дотор үйлдвэрлэлийн нөөц 142 сая.тн, үүнээс 2021 оны 12 сарын 01-ний байдлаар 37.28 сая.тн нүүрс олборлосон ба үлдэх 104.7 сая.тн нөөцийг жилийн 9.0 сая тонн хүчин чадлаар 12 жил ашиглах юм.

Овоот Толгой нүүрсний уурхай төслийн ерөнхий мэдээллийг Хүснэгт-1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Саусгоби сэндс ХХК
Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9019019096 (Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар)
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, Ашигтмалтын хайгуул хийх, Ашигт малтмалын ашиглалт
Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, стадион оргил махатма ганди, 22, Моннис Бьюлдинг 8-р давхар
Захиралын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Шюй Жинь Шөн; 976-70070710; 3334 jinsheng.xu@southgobi.com
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Д.Ариунболд; 976-70070710; 3414 Ariunbold.Dogmisangi@southgobi.com
Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа	Ашигт малтмал ашиглах (нүүрс) MV-012726 2039.09.20 дуустал
Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	Химийн бодис ашиглах № 9019019096 Хүлээгдэж байгаа
Галын дүгнэлт	Нийт 7 объект дээр галын дүгнэлттэй 1. ШТС 2. Ажилчдын хотхон 3. Засварын цех, 4. Нисэх онгоцны буудал 5. Гаалийн үйлчилгээ-1/нармандах уурхай/ 6. Гаалийн үйлчилгээ-2/наржаргах уурхай/

	7. Нүүрс угаах үйлдвэр
Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	Нэгдсэн агуулах дотор химийн бодис хадгалах тусгай төмөр шүүгээ бүхий хэсэгтэй. Агуулахыг 2013 онд улсын комисст хүлээлгэж өгсөн ба мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй.
Орон нутагтай газар эзэмшлийн тухай хийсэн гэрээний огноо, баталсан хуулийн этгээдийн нэр, албан тушаал, байгууллага	Дугаар: Нийт 28 газар эзэмших гэрчилгээтэй Бүгд сунгагдсан болно
Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	Нэмэлт тодотголын ерөнхий үнэлгээ баталсан огноо: 2012.09.05 өдөр БОНХЯ баталсан.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан 2016 онд хийгдсэн ба 2022 онд нэмэлт тодотгол хийгдэж байна.
Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	Ус ашиглах дүгнэлт БОМТ-гөө батлагдсаны дараагаар Усны газраар гаргуулна.
Төслийн нэр	Овоот Толгой нүүрсний уурхай
Төслийн харьяаллын байршил	Бага овоо баг, Гурвантэс сум, Өмнөговь аймаг
Төслийн ангилал	Нүүрсний олборлолт
Төсөл эхэлсэн огноо	2008 он
Төсөл хэрэгжих хугацаа	2039 он хүртэл
ТЭЗҮ баталсан огноо	2022 он
2022 оны бүтээгдэхүүний хэмжээ /дундаж/ 12 сарын 31-ний өдрийн байдлаар	Хуулсан хөрс: 3.58 сая м ³ Олборлосон нүүрс: 0.69 сая тонн Экспортолсон нүүрс: 1.22 сая тонн

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчны төлөв байдал

2.1.1. Физик газарзүйн онцлог

Овоот Толгой уурхай орших Нарийн Сухайтын нүүрсний сав газар нь физик газарзүйн мужлалтын хувьд Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид хамаарна. Хойд талаараа Бумбын нуруу (2360 м), Тостын нуруу (2517 м), Тахилгын хяр (2316 м) гэсэн 30 км өргөнтэйгөөр 180 км үргэлжлэх уулсаар хүрээлэгдсэн, уулнаасаа эх аван газрын гадаргуугаа дагасан урагш чиглэсэн хэдэн арван км үргэлжлэх хуурай сайруудаар ихээхэн хэрчигдсэн газар юм. Тус сумын нутаг дэвсгэрт Алтайн нурууны үргэлжлэл болох хэд хэдэн эгнээ нам уулт өндөрлөг, тэдгээрийн хоорондох өргөн уудам хоолой хөндийн хэсэг хамаарагдана. Ордын дүүргийн харьцангуй өндөр 1525-1545 м.

2.1.2. Цаг уур, уур амьсгал

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл -15-20⁰С хүйтэрч, зун +30 -35⁰С заримдаа +40⁰С хүрч халдаг. Жилдээ дунджаар 98-102 мм орчим тунадас унадаг. Хур тунадасны бараг 90-95% нь дулаан улиралд буюу 7 8 дугаар саруудад орох бөгөөд хүйтний улиралд тун бага тунадас унадаг. Өвөл 0-3 мм, зун 30-60 мм, жилд 100 мм- ээс бага тунадас унана.

2.1.3. Гадаргын болон газар доорх усан сүлжээ

Төслийн талбай болон түүний орчмоор Хацавч, Дов, Хэлтгий малгайт, Товхон, Хөөвөр, Хөх Толгой, Нарийн Сухайт, Жигдэн зэрэг хуурай сайрууд дайран өнгөрнө. Чулуулаг массивын доторхи сайрууд, өгөршлийн бүсэд газар доорх ус нь гар худгуудын үр дүнгээр тогтоогдсон ба ундарга нь гол төлөв 0.1 л/с буюу ерөнхийдөө тэнд уулын чулуулгийн ан цавын ус агууламж

бага байна. Ордын хэмжээнд үүссэн тектоник хагарал-тохойрлын гүний усны орчимд эрдэжилт бага, харьцангуй цэнгэг (0.8 г/л) устай, тохойрлоос холдох тутам тухайлбал Зүүн хэсэгт нь усны эрдэжилт 4.5 г/л сульфатлаг-хлорт натрийн найрлагатай нь ажиглагддаг байна.

Тус бүс нутаг түр зуурын урсацтай бүсэд хамаарна. Зөвхөн эрчимшил ихтэй хур борооны үед бага зэргийн гадаргын урсац хуурай сайруудаар үүсэж зарим хотгор хонхор газрыг дүүргэх нөхцөлтэй.

2.1.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайн хойд хэсгээр орших нам уулсаар уулын хээржүү цөлийн цайвар бор хөрс тархаж байхад Хүрэн овоо, Зангад Толгой зэрэг алсын бараа харах өндөрлөгүүдтэй хуурай сайраар хэрчигдсэн аараг толгодоор сул хөгжилтэй чулуурхаг бор саарал хөрстэй. Хуурай сайр ихтэй Ховхийн хөндий нэртэй хэвгий талархаг газраар цөлийн гөлтгөнөт бор саарал хөрс нийтлэг тархана.

2.1.6. Ургамлын аймаг

Овоот Толгой уурхайн лицензийн талбай байрлах газар нутаг нь Өмнөговь аймгийн Гурвантэс сум, манай орны ургамалшлын бүс бүслүүрийн хувьд Цөлийн бүс, Ургамал-Газарзүйн мужлалаар Говь-Алтайн цөлөрхөг хээрийн, баруун хэсэг Алтайн Өвөр говийн, өмнөд хэсэг Алашаа говийн тойрогт хамаарна. Монгол орын ургамал газарзүйн мужлалаар тус тойрог нь бусад тойргуудаас зүйлийн бүрдлээр хамгийн ядмаг газар.

Цөлөрхөг хээрийн бүс нь Монголын хээр, Төв Азийн цөлийн зааг дээр нилээд эрт үүсэж бий болсон, зөвхөн энэ бүсэд ургадаг зонхилгогч ургамлуудтай байдгаараа онцлогтой. Цөлөрхөг хээрийн бүсэд жилдээ ихэвчлэн 100-125 мм хур тундас унана. Ургамал ургах хугацаа 170-190 хоног үргэлжлэх боловч байнга гандуу юмуу гантай, хүчтэй салхи, шороон шуургатай байдаг нь ургамлын амьдралд муугаар нөлөөлдөг.

2.1.7. Амьтны аймаг

Овоот Толгой нүүрсний уурхай орших Нарийн сухайтын сав газар нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Говь Алтай уулын тойрог, Алашаа говийн цөлийн тойрогт багтдаг. Иймд төслийн талбайн хойд бие үргэлжилсэн цавчим өндөр хадархаг уулсаар хүрээлэгдсэн бол талбайн урд хэсэг нам, хайргархаг бэсрэг толгод, тэгш талархаг гадаргуутай, талбайн хүрээнд байнгын урсацтай булаг, шанд уст цэгүүд олон тул амьтны зүйлийн тооны хувьд харьцангуй баялаг газар юм.


Уурхайн лицензийн талбай түүний ойр орчмоор 2005 оноос хойш хийсэн БОНБНУ тайлан, түүний нэмэлт тодотголууд, мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлсэн судалгаанаас харахад нийт 22 зүйлийн хөхтөн, 86 зүйл нүүдлийн болон суурин шувуу, 13 зүйлийн мөлхөгчид, хоёр нутагтан, 380 зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдсэн байна.

2.2. Төслийн нийгэм-эдийн засгийн төлөв байдал

2.2.1. Овоот Толгой төслийн байршил

Овоот Толгой уурхай (12725А тусгай зөвшөөрөл бүхий 9308 га талбай) нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэр V буюу Бага овоо багийн нутагт, Хөвхийн хөндий–Нарийн сухайтын нүүрсний орд газарт, Даланзадгад хотоос 320 км, нийслэл Улаанбаатар хотоос 950 км зайд, баруун өмнөд зүгт, Шивээ-Хүрэнгийн боомтоос 56 км-т (х.ө 42'59"619, з.у 101'16"83, өндөршил д.т.д 1526 метр) оршдог.

Овоот Толгой уурхайн байршил



Зураг 3. Лицензийн талбайн байршил

2.2.2. Хүний нөөц

Саусгоби сэндс ХХК-ийн хүний нөөцийн бодлогын хувьд уурхайн хүний нөөцийг орон нутгаас бүрдүүлэхийг эрмэлзэж орон нутгийн иргэдийг сургаж улмаар мэргэжил олгон ажлын байраар хангаж, улам мэргэшүүлж дадлагажуулж ажиллуулахыг эрмэлзэж ажилладаг. Бид зөвхөн өөрийн боловсон хүчнийг сургаж бэлтгээд зогсохгүй орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлийн боловсон хүчинг бэлгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Их дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг санхүүжүүлэн хэрэгжүүлдэг.

Саусгоби сэнд ХХК-д 2023 оны 3-р сарын 05 байдлаар нийт 328 хүн ажиллаж байгаагаас Овоот Толгой уурхайд 284 хүн ажиллаж байна. Үүнээс Гурвантэс сум-74, Ноён сум-3, Сэврэй сум-16, Даланзадгад-29, УБ хот болон бусад аймгаас-162 тус тус байна.




График 1. Хүний нөөцийн бүрэлдэхүүн

2.2.3. Дагалдах дэд бүтэц

Уурхай байрлах тус бүс нутагт “МАК” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Магнай Трейд” ХХК, “Вагнер Азия” ХХК, “Бласт” ХХК, “Өсөх зоос” ХХК зэрэг олон аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаа тул зам, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн. Овоот Толгой уурхайн хувьд MV-012726 тусгай зөвшөөрлийн 9312,27 га талбайн 1358,41 га талбайд уурхайн эдэлбэр болон бусад барилга байгууламжуудыг барьж байгуулан газрыг зохих зөвшөөрлийн дагуу ашиглаж байна. Үүнд ажилчдын хотхон, уурхайн захиргааны цогцолбор, механик цех, материал хангамж, хадгалалт хариуцсан агуулах, тогтмол нислэг бүхий нисэх буудал, шатахуун түгээх станц, нүүрсний чанарын лаборатори, нүүрс угаах үйлдвэр болон бусад байгууламжууд орно.

Хүснэгт 2. Төслийн талбайн байгууламжууд

№	Газрын байршил	Зөвшөөрөлтэй газрын хэмжээ, га
1	Уурхайн ажилчдын тосгон	10
2	Хүнд машин механизм засварын газар	34.2
3	Тэсэлгээний агуулах	4
4	Аммиак эмульсийн үйлдвэр	4
5	Нүүрсний агуулах склад	19.1
6	Авто зам	33.6 км
7	Өндөр хүчдэлийн шугам	4.1 км
8	Өндөр хүчдэлийн шугам	3.15 км
9	ШТС-ын агуулах	7.5
10	Нүүрс баяжуулах үйлдвэр /хуурай үйлдвэр/	130.74
11	Нүүрс угаах үйлдвэр нойтон аргаар	32.4
12	Нүүрс агуулах талбай	26.8
13	Наржаргах уурхайн овоолго	487.52
14	Нармандах уурхайн овоолго	244.1
15	Нармандах уурхайн өргөтгөл	24.2
16	Наржаргах уурхай	165.34
17	Нармандах уурхай	121.36
18	Нисэх онгоцны буудал	72.56
19	Цэвэрлэх байгууламж	0.3
20	Үерийн уснаас хамгаалах далан	1.09
Нийт		1358.41 га, 40.85 км

2.2.3.1. Ажилчдын тосгон

Овоот Толгой уурхай нь 2009 онд 292 хүний багтаамжтай ажилчдын тосгон бариулж ашиглалт оруулж мөн 2011 онд 312 хүн амьдрах боломжтой үйлчилгээ, конторын өргөтгөл бүхий шинэ барилга ашиглалтанд оруулснаар нэг ээлжиндээ нийт 608 орчим хүн хүлээж авах хүчин чадалтай тосгон болж өргөжсөн. Үүнд:

- Уурхайн тосгон нь ажилчдын амьдрахад өрөөнүүд 1-4 ортой, 1 ороной, 2 ортой, VIP өрөө бүхий зохион байгуулалттай.
- Ажилчдын амралт чөлөөт цагт зориулж теннис, бялдаржуулах өрөө, бильяардын, ТВ өрөөг, спорт цогцолбортой.
- Өндөр хүчин чадалтай бүрэн автомат угаалгын машин, хатаалгын машин болон цагаан хэрэглэл индүүддэг зориулалтын машин зэрэг иж бүрэн тоног төхөөрөмжтэй угаалгын цех ажилладаг.
- Гал тогоо нэг ээлжиндээ 350 хүн зэрэг хооллох хүчин чадалтай, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Нарийн боов, зуух, мах, ногоо бэлтгэлийн өрөө тус тусдаа ба эрүүл ахуйн стандартын шаардлага бүрэн хангагдсан.

- Ажилчдын ээлж сольдог 25 хүний суудалтай Ниссан автобус, 45 хүний суудалтай Daewoo автобус тус бүр хоёр нийт 4 автобустай. Уул, Баяжуулах, Засварын хэлтсүүдийн ажилчдыг өглөө, оройн ээлжээр сольдог ба Гурвантэс сумын ажилчдыг хувиарт ээлжээр зөөж байна.



Зураг 4. Уурхайн ажилчдын тосгон

2.2.3.2. Засварын газар

Засварын хэлтэс нь уурхайн хүнд машин механизм, тоног төхөөрөмж, техникийн засвар үйлчилгээ, бэлэн байдлыг хангаж ажилладаг ба тоног төхөөрөмжүүдийн ажилласан мот/цагаас хамааруулж урсгал засвар болон их засварын ажлуудыг тогтмол гүйцэтгэдэг.

Засвар үйлчилгээний төв нь 24 цагийн тасралтгүй ажиллагаатай бөгөөд дараахь цех тасгуудаас бүрддэг. Үүнд:

1. Гагнуурын хэсэг.
2. Дугуй засварын хэсэг.
3. Урсгал засварын хэсэг
4. Угаалгын хэсэг
5. Хувцас угаалгын хэсэг
6. Гар болон жижиг оврын багажны өрөө
7. Хувцас солих өрөө
8. Албан тасалгаанууд
9. 60 хүний хооллох танхим
10. 30 хүний сургалтын танхим
11. 30 хүний хурлын заал
12. 30 хүний гэрээт болон өөрийн ажилчдын контор
13. 5 хэсэг бүхий MT4400 засварлах засварын хэсэг



Зураг 5. Засварын газар

Мөн Хангамжийн хэлтэс нь материал татан авалт хадгалалтыг өргөтгөх зорилгоор нэмэлт өргөтгөл барьж холбогдох газруудад хүлээлгэн өгсөн.

2.2.3.3. Шатахуун түгээх станц

Манай компани уурайн хэрэгцээг хангах зорилгоор 2008 онд “Гурван зам” ХХК-ны барьж байгуулсан Шатахуун Түгээх Станцыг 2011 онд худалдан авсан ба өөрийн шатахууны дотоод хэрэгцээг тус ШТС-аас хангаж байна. Тус ШТС нь нийт 1300 м³ багтаамжтай бөгөөд түүний 80%-д шатахуун цэнэглэж дунджаар 1200 м³ шатахууны нөөцтэй ажилладаг.



Зураг 6. Шатахуун түгээх станц болон агуулах

2.2.3.4. Цахилгаан хангамж

Уурхайн тосгоны цахилгаан хангамжинд Atlas Copco Q1X165 120 кВт хүчин чадалтайг, нисэх буудлын цахилгаан хангамжинд Olympian GELH30 21.6кВт хүчин чадалтай, түр засварын газарт Plamas GSW170D 127кВт хүчин чадалтай дизель цахилгаан үүсгүүрүүдийг тус тус хэрэглэнэ.

Уурхайн гэрэлтүүлэг: Уурхайн шөнийн ээлжинд уулын ажил явагдаж байгаа хэсгүүд болон овоолгын ахилтын хэсгүүд дээр “Ingersoll Rand”-ийн 10 ширхэг хөдөлгөөнт дизель гэрэлтүүлгийг ашигладаг.

Нүүрсний агуулах болон тэсрэх материалын агуулахууд нь генератороор тэжээгддэг суурин шонгууд бүхий гэрэлтүүлэгтэй.

2.2.3.5. Дулааны сүлжээний усыг халаах нам даралтын зуух


Овоот Толгой уурхайд ажиллагсдын тосгонд байрлах 1-CLSG-308 2-CLSG-240 3-CLSG-60, засварын төвд байрлах 1-CLSG-90 2-CLSG-20 3-CLSG180 маркын дулааны сүлжээний усыг халаах нам даралтын ус халаалтын зориулалт бүхий зуухнуудтай. Тус зуухны засвар үйлчилгээг 2013 оны 10 сард “Терма калор” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн



Зураг 7. Дэд бүтцийн байгууламж Тэсрэх бодисын агуулах

Овоот Толгой нүүрсний уурхай 2022 оноос уул уурхайн тэсрэх материалын үйлдвэрлэл, худалдаа, ханган нийлүүлэлт болон тэсэлгээний үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч “Спэйшил майнинг” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Нүүрсний шинэ агуулах 2009 онд байгуулсан ба 800.000 тонн нүүрс агуулах хүчин чадалтайгаар ашиглалтанд оруулсан. 2010 онд уг агуулахыг гаалийн баталгаат нүүрсний агуулах болгон баталгаажуулсан. Нар мандах уурхайн гаалийн баталгаат агуулахыг 2013 онд барьж ашиглалтанд оруулсан.



Зураг 8. Гаалийн баталгаат агуулах (а. Наржаргах уурхай б. Нармандах уурхай)

2.2.3.6. Нисэх онгоцны буудал

Саусгоби сэндс ХХК Овоотын хилийн цэргийн анги ашиглаж байсан онгоцны буудлыг сайжруулан ашиглаж байна. Овоот нисэх буудал нь сумын төвөөс зүүн урд зүгт 38 километр, уурхайн шинэ кемпээс зүүн зүгт ойролцоогоор 10 км газарт, тусгай зөвшөөрөлтэй талбай дотроо N 43°00'46”, E 101°20'00” солбилцолд байрладаг бөгөөд Саусгоби сэндс ХХК-ийн өөрийн нисэх буудал юм.



Зураг 9. Овоот Аэродром

Овоот нисэх буудал нь хоёр давхар сэндвичэн хавтан барилга, нисэх зурвасын 1,95 км урт хатуу хучилттай зам бүхий нисэхийн цаг уурын бодит ажиглалтын Вайсала (Vaisala) систем, агаар газар болон газар, газрын холбооны суурин станц 2, нөөц станц тус тус 2 ширхэгийг суурилуулсан ба ИНЕГ-ын холбогдох алба салбараас гэрчилгээжүүлэн ашигладаг. Мөн онгоцны газрын цахилгаан тэжээл үүсгүүр, аюулгүй байдлын үзлэгийн бүрэн тоног төхөөрөмжтэй. Одоогоор ковид-19 цар тахлын улмаас нислэг үйлдэгдэхгүй байгаа болно.

2.2.3.7. Зам тээвэр

Өмнөговь аймгаас Гурвантэс сум хүртэлх нийт 1672 км орон нутгийн зам, Даланзадгад-Гашуун сухайтын хилийн боомт-улсын хил хүртэл Даланзадгадаас Цогт-Овоо сумаар дамжин Дундговь аймгийн

хил хүртэлх улсын чанартай замтай байна. Улсын дундаж сайжруулсан замын уртыг Өмнөговь аймагтай харьцуулахад улсын дунджаас 5.9 дахин доогуур замтай байна. Гурвантэс сум орчмын дэд бүтцийн байдал нь харьцангуй сайн хөгжсөн. Сумын төвөөс Овоот Толгой уурхайн талбай руу 34 км сайжруулсан шороон замаар явж очно. Сайжруулсан шороон замыг Саусгоби сэндс ХХК компани Орон нутгийн захиргааны хүсэлтийн дагуу барьж байгуулсан болно. Тус уурхайгаас Хятадын хил хүртлэх нүүрс тээвэрлэх шороон замтай бөгөөд 2010 онд Нарийн сухайтаас Шивээ-Хүрэн хүртэл 45 км хатуу

хучилттай замыг Чинхуа-МАК-Нарийн Сухайт ХХК өөрийн хөрөнгөөр байгуулсан. 2010 онд Саусгоби сэндс ХХК мөн нүүрс тээврийн хүнд даацын 45км зам байгуулах төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2014 оны 9 сар тус төслийг хэрэгжүүлж дууссан.

2.2.3.8. Нарийнсухайт-шивээхүрэн чиглэлийн хүнд даацын концессын авто зам

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад орсон Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам барих концесс олгох уралдаант шалгаруулалтанд "Эн Ти Би" ХХК болон "Саусгоби сэндс" ХХК нарын түншлэл оролцож шалгарсан.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх зорилгоор тус компаниудын хамтран байгуулсан "Ар Ди Си Си" ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 262 дугаар тогтоолын дагуу 2011 оны 10-р сарын 26-ны өдөр Төрийн Өмчийн Хороотой "Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын Барих-Ашиглах-Шилжүүлэх" концессын гэрээг байгуулсан.

Тус концессын гэрээний нөхцөлд заасанчлан төсөл хэрэгжүүлэгч нь арван таван жилийн ашиглалтын дараа төслийн замыг улсын мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгөх үүрэгтэйгээр өөрийн хөрөнгөөр барьж байгуулаад байна.


Төслийн замын эхлэл цэг болох Нарийнсухайт нь Өмнөговь аймгийн баруун өмнөд хэсэг, Гурвантэс сумын 4-р багийн нутагт дэвсгэрт "Өвөлжөө Уул-1"-д оршдог, сумын төвөөс зүүн урд чиглэлд 34 км зайд, Даланзадгад хотоос 320 орчим км, Улаанбаатар хотоос 950 км зайд байрладаг.

Замын ерөнхий гүйцэтгэгчээр "Эн Ти Би" ХХК, Бие даасан зөвлөх инженерээр "Эм Си Пи Сижиар" ХХК нар 2012-2014 онд ажиллаж, зам барилгын ажлыг бүрэн гүйцэтгэж дуусаад байна.

Шинэ замын барилгын ажлын нийт өртөг 109 орчим тэрбум төгрөг бөгөөд уурхайн тээврийн хүнд даацын машин явахад зориулагдсан (нэг тэнхлэгийн даац 26 тн), 25 см цементээр бэхжүүлсэн суурь, 24 см цементбетон хучилттай Монголд анх удаа баригдаж буй зам юм.

Тус зам нь байгаль орчныг хамгаалах, улмаар орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн нөхцлийг бүрдүүлэн, орчны бохирдлыг бууруулах чухал ач холбогдолтой зам юм.

Тус замыг "Хүрэн толгой коал майнинг" ХХК болон "Монголын алт" ХХК, "Өсөх зоос" ХХК, "Жавхлант" ХХК, "Терра Энержи" ХХК-ийн нүүрс тээврийн машинууд ашиглаж байна. Цаашид ч өөр төслүүд ашиглах бүрэн боломжтой юм.




Зураг 10. Нарийнсухайт-шивээхүрэн чиглэлийн хүнд даацын концессын авто зам

2.2.3.9. Бохир ус цэвэршүүлэх байгууламж

Уурхайн тосгон болон засварын газар дахь бохир ус цэвэршүүлэх байгууламжийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг Хятадын “Beijing Longanhuacheng Architectural Designing” Co.,Ltd-ийн хийсэн ажлын зургийн дагуу тус компани хийж гүйцэтгэсэн. Цэвэрлэх байгууламж нь механик, биологи, химийн аргуудаар бохир усыг цэвэрлэх ба төслийн хүчин чадлыг 132 м³ гэж төслийн тайлбар бичигт дурьдсан байдаг.

Одоогоор хоногт дунджаар 60-80 м³ бохир усыг хүлээж авч байна. Бид тус онд уурхайн цэвэрлэх байгууламжуудын технологийн горимыг сайжруулах, цэвэрлэгдэн гарч буй усыг стандартын төвшинд 100% нийцүүлэх зорилгоор Үндэсний зөвлөх Вестминистр ХХК-ийн Монгол улсын зөвлөх инженер Ц. Цацрал ахлагчтай багийг авч ажиллуулан бодит үр дүнд хүрч ажилласан. Мөн 2014 онд сантехникийн ажлыг гүйцэтгэн саарал усаа дахин ашиглаж байна.



Зураг 11. Бохир ус цэвэршүүлэх байгууламж

2.2.3.10. Нүүрсийг нойтон технологиор баяжуулах үйлдвэр

“Саусгоби сэнс” ХХК нь нүүрсний зах зээлийн нөхцөл байдал болон цахилгааны эх үүсвэр зэрэг хүчин зүйлээс шалтгаалж ил уурхайгаас олборлож буй нүүрсийг чанараар /үнслэг, бөсөх индекс/ нь 3 ангилан, нүүрсний агуулахад хураан зөөврийн шигших төхөөрөмжийг ашиглаж ангилалт хийн борлуулсаар ирсэн. Цаашид бохирдол анхдагч нүүрсийг нойтон буюу гравитацийн аргаар баяжуулж борлуулах нь эдийн засгийн хувьд ашигтай бөгөөд туршилт судалгааны ажил дээр үндэслэн баяжуулах үйлдвэрийн төслийн ажлыг гүйцэтгэн НБҮ-г байгуулж, ашиглалтанд оруулаад байна.

НБҮ нь Овоот Толгойн ордын ил уурхайн WF ангилалын нүүрсийг гравитацийн аргаар баяжуулна. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал 1.35 сая тн хүчин чадалтай ажиллана. Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын хувьд 41.5% үнслэгтэй анхдагч нүүрсийг гравитацийн аргаар боловсруулж баяжмалын гарц 50-60%-тай байна. Овоот Толгойн нүүрсийг үнслэгээр нь дараах байдлаар ангилж байна. Үүнд:

- ▶ А нүүрс буюу үнслэгийн хэмжээ <10.5%
- ▶ В нүүрс буюу үнслэгийн хэмжээ 10.5-17,5%
- ▶ F нүүрс буюу үнслэгийн хэмжээ 25%< дээш



Зураг 12. Нүүрсийг нойтон технологиор баяжуулах үйлдвэр

2.2.3.11. Хог хаягдлын цэг

Уурхайн хог, хаягдлын менежментийн үр ашигтай байдал, тогтвортой хэрэгжилтийг хангах нь уурхайн байгаль орчны ажилчдын болон нийт байгаль орчны хэлтсийн голлох үүргийн нэг юм. Уурхайн талбай дээрх хог, хаягдлын менежментийн үр ашигтай хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Уурхайн хэмжээнд хог, хаягдлын эх үүсвэрүүдийг тодорхойлох,
- Уурхайн хог, хаягдлын хэмжээг бууруулахад чиглэсэн журам боловсруулах,
- Хог хаягдалтай холбоотой сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх,
- Үр ашигтай тээвэрлэлт, устгал, дахин ашиглалын горимыг хэвшүүлэх,
- Бүртгэл, тайлангын систем бий болгох, мэдээллийн сан үүсгэх,
- Хог хаягдлын менежментийн үүрэг хариуцлагын механизмыг бүрдүүлэх гэх мэт



Зураг 13. Хогийн цэг (кемп, засвар)

Уурхайн хог, хаягдлын менежментийн хэрэгжилтийг тусгай зөвшөөрөл бүхий, орон нутгийн компани гардан гүйцэтгэх ба байгаль орчны мэргэжилтэн явцын хяналтыг өдөр бүр хийдэг. Гэрээт гүйцэтгэгч нь дараахь ажлыг гүйцэтгэдэг. Үүнд:

- Уурхайн хэмжээнд тогтоогдсон бүх хог хаягдлын эх үүсвэрүүдээс тээвэрлэлт хийж зөвшөөрөгдсөн хогын цэгт буулгах,
- Эх үүсвэр дээрх ангилан ялгалтыг хянах, мэдээллэх,
- Хогийн цэгийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулах,
- Дахин ашиглах эсвэл дахин боловсруулах хаягдлыг ангилах, хувиарлахад туслах,
- Устгах, булшлах хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах, боловсруулах хаягдлын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,
- Хортой болон аюултай хог хаягдлын хадгалалт, хамгаалалтыг хариуцах
- Хог хаягдлын өдөр тутмын бүртгэлийг хөтлөх, тайлан гаргах

2.2.3.12. Төсөлд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт

Саусгоби сэндс ХХК –ийн олборлолт явуулж буй “Овоот Толгой” ил уурхай нь хагас коксжих, дунд болон өндөр үнслэгт нүүрс олборлож байна. Уурхай нь 2008 онд анх олборлолтоо эхлүүлсэн ба “Нармандах” болон “Наржаргах” уурхайн амуудаас (карьер) нүүрс олборлож байна. Уурхайн хүчин чадал нэмэгдүүлэхтэй холбогдон “Техник-эдийн засгийн үндэслэл”-ийг 2015 онд шинэчлэн боловсруулж, батлуулсан ба нарийвчилсан хайгуулаар 345.8 сая тонн (А+В+С) нүүрсний нөөц илрүүлснээс уурхайн хил хязгаар дотор үйлдвэрлэлийн нөөц 142.8 сая.тн, үүнээс 2008-с 2021 оны 12 сарын 31-ний байдлаар 37.28 сая.тн нүүрс олборлосон ба үлдэх 104.7 сая.тн нөөцийг жилийн 9.0 сая тонн хүчин чадлаар 12 жил ашиглах юм.



Наржаргах уурхайд олборлолт явуулж буй байдал


Ордын уул геологийн нөхцлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг эксковатор, автосамосвалын хослолоор гүйцэтгэх ашиглалтын системийг сонгосон. Хөрсийг гадаад болон дотоод овоолгод, нүүрсийг баяжуулах үйлдвэр хүртэл, баяжмалыг төмөр замын дэргэдэх агуулах хүртэл, хаягдлыг хөрсний гадаад овоолгод тус тус тээвэрлэнэ. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалтыг Хүснэгт 3–д үзүүлэв.

Хүснэгт 3. Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмж

№	Техникийн төрөл	Тоо
1	Экскаватор	8
2	Хүнд даацын автомашин	33
3	Дугуйт ачигч	5
4	Түрэгч	6
5	Дугуйт түрэгч	3
6	Грейдер	3
7	Өрөм	9
8	Бутлуур	4
9	Дунд оврын автомашин	21
10	Суудлын машин	49
11	Бусад тоног төхөөрөмж	110
	Нийт	251



Зураг 14. MT 4400 хүнд даацын машин



Зураг 15. PV275 Тэсэлгээний өрөм, Экскаватор

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Овоот Толгой уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг “Майк Грийн” ХХК 2016 онд боловсруулан БОАЖЯ-аар батлуулсан билээ. Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоох зорилгоор “Майк Грийн” ХХК-ийн шинжээчид 2022 оны 7-8 саруудад төслийн газар дээр нь очиж орчны төлөв байдалд ажиглалт, тандалтын судалгаа хийсэн.

БОННУ тайлангийн нэмэлт тодотголын ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, БОАЖЯ-ны шинжээчийн гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тавьсан шаардлага зэргийг үндэс болгосон ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх талаар Дэлхийн банк болон НҮБ-ын Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комиссоос гаргасан арга зүй зэргийг баримталсан болно.

Манай компани ордыг ашиглаж эхэлсэн 2008 оноос эхлэн олборлолтын ажил эрчимтэй тасралтгүй явагдсан ирсэн ба ордын хэмжээнд нийт 37.2 сая.тн нүүрс олборлож, 128.04 сая.м³ хөрс хуулж, одоогийн байдлаар 1474.9 га газар уурхай болон уурхайн холбогдох объектуудаар ашиглалтад өртөж байгалийн ландшафтын оронд үүсмэл ландшафт бүрдэх, газрын нөөц багасах, газрын гадаргын хэв шинжид өөрчлөлт бий болгосон байна.

Овоот Толгой нүүрсний уурхайн байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа 2009 оноос эхлэсэн бөгөөд сүүлийн 11 жилийн хугацаанд нийт 147.84 га талбайд техникийн, 55.16 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж орон нутаг, улсын комисст хүлээлгэн өгсөн байна. 2020 оны нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд орон нутгийн тавьсан саналын дагуу Гурвантэс сумын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд бусад уурхайтай хамтран оролцож байна.

Хүснэгт 4. Овоот Толгой уурхайн нөхөн сэргээлтийн мэдээлэл

Нөхөн сэргээлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Биологийн нөхөн сэргээлт (га)	6.18	15.6	10.6	14.2	1.6	2	-	1.68	1	1	1.3
Техникийн нөхөн сэргээлт (га)	8.1	18.6	16.2	17.2	1.6	2	25.3	1.68	1	1	1.3
Нийт нөхөн сэргээсэн талбай (га)											147.84

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “Майк Грийн” ХХК Овоот Толгой уурхайн Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг дараах байдлаар нэгтгэн урьдчилан тогтоолоо. Үүнд:

- Төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна. Харин төслийн үйл ажиллагааны үр дүнд газар нутгийн эмзэг байдлаас шалтгаалж сөрөг нөлөө үүсэх, үүссэн сөрөг нөлөө хуримтлагдаж болзошгүй нөхцлүүд байх боломжтой байна.
- Тус төслийг ил аргаар олборлоход газрын хэвлий 260 м хүртэл гүнд эвдрэлд орж, уурхай, дэд бүтцийн барилга байгууламж, зам талбай зэрэгт 1,778.1 га талбайн гадарга, хөрс, ургамалан нөмрөг нөлөөлөлд өртөхөөр байна.
- Уурхайн ашиглалтын хугацаанд талбайн геологийн тогтоц, үржил шимт хөрс хуулагдаж, ургамлын нөмрөгийн бүрэн бүтэн байдал, органик нэгдлийн хуримтлал сарнин устаж, хөрс ургамлын үе давхаргад тархан төлжиж амьдарч байсан бичил организм, шавьж хорхой, сээр нуруугүйтэн болон бусад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, амьдралын хэвийн тогтолцоо тодорхой хэмжээгээр алдагдана.
- Газрын гүний усан орчны нөөцөд сөргөөр нөлөөлнө.
- Үйл ажиллагааны явцад нилээд хэмжээний тоос шороо босч ил гарсан гадаргуугаас салхиар зөөгдөн ойр хавийн ялангуяа салхины давамгайлах чиглэлийн дагуу хөрс ургамлыг дарж байгалийн өнгө төрхийг муутгах, ойролцоох айлууд, ургамал, амьтны хэвийн амьдрах нөхцөлийг алдагдуулна.

Саусгоби сэнс ХХК нь БОНБНУ-ний үнэлгээгээр тогтоогдсон эдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзсэн тэдгээр сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

3.1. Ил уурхайн нүүрс олборлох үеийн болзошгүй нөлөөлөл

Овоот Толгойн уурхайгаас нүүрс олборлох уурхайн технологи ажиллагаа, түүнийг хаах үеийн Леопольдын матрицыг дараах хүснэгтээр үзүүлж уурхайн технологийн үе шат бүр байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх эрчмийн байдлыг үзүүлэв. Ийнхүү Леопольдын матрицын аргаар дүгнэж үзэхэд ил уурхай технологийн үе шатуудаас хөрс хуулалт, тэсэлгээ, өрөмдлөг, нүүрс тээвэрлэлт, овоолго үүсгэх, нүүрс угаах зэрэг үйл ажиллагаа нь тухайн орчиндоо нөлөөлөл үзүүлнэ.

Хүснэгт 5. Ил уурхайн үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь (БОННУ тайлангаас 2016 он)

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	өрөө	Богино	Урт хугацаанд	Буцаж	Буцалгүй	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт	x				x		x			x
Гадаргын усны урсацын өөрчлөлт	x				x		x	x		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x		x	
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x			x		x			x
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын доорх нөөц баялаг	x				x		x		x	
Бэлчээрийн байдал	x				x		x			x
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	

Эрчим хүчний нөөц	x				x		x			x
3.Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт	x	+			x		x			x
Гадаргын усны чанарын өөрчлөлт	x			x					x	
Агаарын бохирдол	x				x		x			x
Хөрсний бохирдол	x				x		x			x
Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх		x		x		x			x	
Дуу чимээ, шуугианы нөлөө	x				x	x			x	
4.Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
5.Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x	x		
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x	x		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		x	
Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x			x
6.Бусад нөлөөлөл										
Ашиглалтын үед шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x			x
Байгалийн урсгал болон хур тунадасны усаар дамжин усны химийн найрлага өөрчлөгдөх, хүчиллэг урсац бий болох	x			x		x			x	
Уурхайн хананы тогтвортой байдал алдагдаж гулсалт нуралт үүсэх	x			x		x				x
Хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга		x		x		x				x
Дүн	25	4	-	5	24	4	24	5	11	13

Тус уурхайн үйл ажиллагаанаас үүдэн гарч болох болзошгүй нөлөөлөл 29 байна. Эдгээр болзошгүй нөлөөллийн чиглэл, үргэлжлэх хугацаа, эрчим тус бүр нь байгаль орчин, нийгэм эдийн засагт хэрхэн үйлчлэхийг авч үзсэн дээрхи хүснэгтээс дараах дүгнэлт гарч байна.

Шууд нөлөөлөл: Энд нийт нөлөөллийн ихэнх буюу 25 нөлөөлөл хамрагдаж нийгэм-эдийн засагтай холбоотой 4 нь эерэг, бусад нь сөрөг нөлөөлөл байна. Үүнд: ил уурхайн хөрс хуулалт, тэсэлгээ хийх, нүүрс ачих, сул чулуулаг болон хаягдлын овоолго хийх зэрэг үйл ажиллагаанаас шууд шалтгаалж газрын тогтоц өөрчлөгдөх, хөрс эвдэрч элэгдэх болон бохирдох, усны чанар ба урсацад өөрчлөлт орох, орчны тоосжилт нэмэгдэх, уурхайн машин механизмын дуу чимээ тасралтгүй гарах, ландшафтын өнгө, хэлбэр болон байгалийн төрх өөрчлөгдөх, болзошгүй ослын үед гарч болох ахуйн бохир ус ба нефтийн бүтээгдэхүүний алдагдалаас хөрс, газрын доорх ус бохирдох, энэ бүхэн нь байгаль орчин зэрэгт сөрөг нөлөөлөх, харин энд ажлын байр болон орон нутгийн хөрөнгө оруулалт, татварын орлого нэмэгдэх, орон нутагт ядуурал буурах зэрэг эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Шууд бус нөлөөлөл: Үүнд: машин механизмын хөдөлгөөн, дуу чимээнээс зэрлэг ан амьтад үргэх дайжихад хүргэх, эдэлбэр газар, түүний орчны эвдэрсэн хөрс, дотоод тээврийн зам, ил овоолго зэргийн тоосжилтоос агаар, хөрс бохирдож уур амьсгалын бичил өөрчлөлт, болзошгүй байгалийн аюул осол (газар хөдлөл, хүчтэй салхи, гал түймэр) гарах зэрэг нөлөөлөлийг шууд бус нөлөөлөлд хамааруулаа.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа: Нийт нөлөөллийн ихэнх буюу 24 нь энд урт хугацаанд, 5 нь богино хугацаанд үргэлжлэхээр байна. Ил уурхайн олборлолтоос үүсэх байгаль экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны чанарын өөрчлөлт, улс орны болон орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх болзошгүй нөлөөлөл зэрэг нь бараг бүгд урт хугацааны нөлөөлөл гэж үзсэн болно. Ажилчдын кемпийн ахуйн бохир усны шугам хоолойд гарах болзошгүй осол, байгалийн болон гэнэтийн осол гарах зэрэг нөлөөлөл богино хугацаанд үргэлжилнэ.

Нөлөөллийн эргэлт буцалтгүй байдал. Энд нийт болзошгүй сөрөг ба эерэг нөлөөллийг буцалтгүй ба буцаж эргэж нөлөөлөх гэж 2 хэсэгт хувааж авч үзлээ. Уурхайн олборлолтын бүхий л үйл ажиллагааны үед газрын тогтоц, орчны хөрс, ургамал, гадаргын ба газрын доорх усны урсацын ба чанарын өөрчлөлт, зэрлэг ан амьтдын амьдрах орон зайн өөрчлөлт, агаарын тоосжилт зэрэгтэй холбоотойгоор байгалийн өнгө төрх, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх нөлөөлөл нь эргэлт буцалтгүй байх болно. Харин уурхайд ажилладаг машин механизм, тоног төхөөрөмжийн болон тэсэлгээний үед гарах дуу чимээ, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн асгарч алдагдсан тохиолдолд гарах хөрс, усны бохирдол, хог хаягдал ариутгаагүй, тухай бүрд нь устгаагүйгээс гарах сөрөг нөлөө, уурхайн осол ба байгалийн болзошгүй гамшгийн үед гарах сөрөг нөлөөллүүд нь буцаж уурхайн үйл ажиллагаа болон байгаль орчинд хүн амын амьдрах орчин, тэдний эрүүл мэндэд буцаж нөлөөлж болзошгүй байна.

Нөлөөллийн эрчим Дээрхи хүснэгтээс үзэхэд уурхайн хувьд нийт нөлөөллийн 17,2% нь хүчтэй, 37.9% нь дунд зэргийн эрчимтэй, 44.9% нь бага зэргийн (сул) эрчимтэй нөлөөлөхөөр байна.

3.2. Хуримтлагдах нөлөөлөл

Ямар хүн, эсвэл ямар байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран тухайн нутаг дэвсгэрт хэрэгжсэн, хэрэгжиж буй, мөн ирээдүйд хэрэгжих төслийн нөлөөлөл дээр тухайн төслийн нөлөөллийг нэмэхэд тэдгээрийн нийлбэр үр дагавраас үүсэх байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг “хуримтлагдах нөлөөлөл” гэнэ.

Нарийн сухайтын районд 2003 оноос хойш нүүрсний олборлолт явагдсаар одоогоор тус бүсэд “Саусгоби сэндс” ХХК-аас гадна “Хүрэн толгой коал майнинг” ХХК болон “Монголын алт” ХХК, “Өсөх зоос” ХХК-нд үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр компаниудын үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж буй сөрөг нөлөөлөл 2003 оноос эхлэн тооцогдох юм. Овоот Толгой төслийг 2007 онд хайгуул эхлэхээс өмнө төсөл хэрэгжих явцад баригдах үйлдвэрийг барьж байгуулах, үйлдвэрлэлийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа болон орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэхээр байна.

Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагаа болон бүс нутагт хэрэгжиж буй бусад төслүүдээс үүсэлтэй болзошгүй хуримтлагдах нөлөөлөл

№	Хуримтлагдах нөлөөлөл	Нөлөөллийн шалтгаан	Хамрах цар хүрээ	Үргэлжлэх хугацаа
1	Газрын доорх усны нөөц багасах	Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал	Төслийн талбай, орон нутаг	Одоо, ирээдүйд
2	Ургамлан нөмрөгийн доройтол	Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа	Төслийн талбай, орон нутаг	Өнгөрсөн, одоо, ирээдүйд
3	Агаарын бохирдол нэмэгдэх	Хуурайшилт, тоосжилт, нүүрсний тоосжилт бусад төслүүдийн бохирдолын давхцал	Төслийн талбай, орон нутаг	Одоо, ирээдүйд
4	Хөрсний бохирдол	4 төслийн үйл ажиллагаа, зам тээвэр	Төслийн талбай, бүс нутаг	Өнгөрсөн, одоо, ирээдүйд

5	Амьтны аймаг дайжих	4 төслийн үйл ажиллагаа	Орон нутаг, төслийн талбай,	Одоо, ирээдүйд
6	Нутгийн иргэд	Байгаль орчны бохирдол, усны хомсдол	Орон нутаг	Өнгөрсөн, одоо, ирээдүйд

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шатуудад мониторинг байнга хийж байхыг зөвлөж байна. Тус бүс нутагт дээрхи төслүүдийн үйл ажиллагаанд байгальд ээлтэй техник технологи, менежментийг зөрчих эсвэл өөр нэмж ямарваа нэг буюу хэд хэдэн ижил төстэй үйл ажиллагаа явуулах тохиолдолд бүс нутгийн экосистем бүрэн эвдэрч, экологийн тэнцвэргүй байдал үүсэх нь боломжтой.

Экологийн тэнцвэр алдагдах тохиолдолд нутгийн ховор, нэн ховор амьтан ургамлын аймаг устгах, хөрсний үржил шим алдагдаж ган, зудын давтагдал ойртох, ширүүн бороо хуй салхины хүч ихсэж гадаргын болон гүний усны нөөц алдрах улмаар гэнэтийн хур борооны үер буух үзэгдэл бий болох боломжтой. Иймд хуримтлагдах нөлөөллийг сайтар үнэлж, тухайн экологийн асуудал тулгарах бүр “Саусгоби сэндс” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК болон “Монголын алт” ХХК, “Өсөх зоос” ХХК-д нэгдэж, нэгдсэн байгаль орчны тулгамдсан асуудлаа хэлэлцэн, асуудлыг эрт үед нь шийдвэрлэх ёстой.

Бид хуримтлал нөлөөллийг үнэлэх ажлын хүрээнд 2016 оноос Нарийн Сухайтын нүүрсний бүлэг ордод үйл ажиллагаа явуулж буй уурхайнуудтай нэгдэж Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн (ОХШХ) хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.3. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн ангилал, цар хүрээ, эрчим давтамж

№	БО бүрэлдэхүүн	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Цар хүрээ	Эрчим, давтамж	Нөлөөлөл үргэлжлэх хугацаа
1	Агаар	Тоосжилт үүсэх	Тэсэлгээ, өрөмдлөг, хөрс хуулалт, хөрсийг ачих, тээвэрлэх, асгах, хаягдал чулуулгийн овоолго үүсгэх. Нүүрсийг олборлох ачих, тээвэрлэх зэрэг үйл ажиллагаанаас	Тоос дэгдэх газрын салхины чиглэл, хурдаас хамаарч тоосжилтын цар хүрээ 0-4км	Тоос дэгдэж буй эхэллийн цэгээс нөлөөллийн эрчим их, зай холдох тусам бага	Уурхайн ашиглалтын хугацаанд
2	Хөрс	Хөрс бохирдох	Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас үүдэж хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах	Асгаралтын хэмжээ талбайнаас хамаарах	Нөлөөллийн эрчим огцом-алгуур	Уурхайн ашиглалтын явцад асгаралт үүссэн тохиолдолд
3	Гадаргын ус	Усны өнөөгийн боломжит эх үүсвэрүүд хомсдох	Уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор газрын гадарга өөрчлөгдсөнөөр гадаргын урсацын голидролд өөрчлөлт орох	Уурхайн хэмжээнд нийт 1228.18 га талбайд газрын гадарга өөрчлөгдөнө.	Нөлөөллийн эрчим алгуур	Уурхайн ашиглалтын явцад
4	Гүний ус	Бага гүний уст үеүүд бохирдох	Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бохир усны алдагдал, нэвчилтээс бохирдох	Асгаралтын хэмжээ талбайнаас хамаарах	Огцом-Алгуур	Асгаралт үүссэн тохиолдолд
5		Газрын доорх усны түвшин, нөөц хомсдох	Ус шавхалтын улмаас уурхай орчмын болон түүний ойролцоох газрын доорх усны түвшин буурах, нөөц хомсдох	Уурхайн ашиглалтын явцад ТЭЗҮ-д тусгагдсанаар хоногт нж-1069.76м ³ нм-2016.48м ³	Нөлөөллийн эрчим алгуур	Уурхайн ашиглалтын явцад
6		Ахуйн болон үйлдвэрлэлийн бохир ус алдагдах	Хаягдал ус цэвэршүүлэх байгууламжаас гарч болзошгүй эвдрэл гэмтлээс бохир усны асгаралт үүсэх	Цэвэрлэх байгууламжийн ойр орчимд 0-0.5км	Нөлөөллийн эрчимд дунд	Уурхайн ашиглалтын явцад
7	Ургамал	Байгалийн ургамал устах	Ил уурхайн ухлаг, овоолгууд болон бусад барилга байгууламжуудыг байгуулах явцад ургамлан бүрхэвчийг хуулах	Нийт 1228.18 га талбайн ургамалд шууд нөлөөлөлөх	Нөлөөллийн эрчим огцом	Уурхайн ашиглалтын явцад

№	БО бүрэлдэхүүн	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Цар хүрээ	Эрчим, давтамж	Нөлөөлөл үргэлжлэх хугацаа
8	Амьтан	Мал, амьтан үхэж үрэгдэх	Уурхайн ухааш, нүх, суваг шуудуунд мал, амьтан унах, ялангуяа салхи, шуурганд уруудсан мал уурхайн ухашинд олноороо унаж үхэж үрэгдэх	Уурхайн ухлагт өртөх талбай 310.9 га	Нөлөөллийн эрчим дунд	Уурхайн ашиглалтын явц
9		Мал, амьтны бэлчээр хомсдох	Уурхайн үйл ажиллагаанаас малын бэлчээр, зэрлэг амьтны амьдрах орчин, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал, өвсөн тэжээлтэн амьтдын бэлчих боломжгүй газрын хэмжээ 4880 га талбай	Нөлөөллийн эрчим дунд	Уурхайн ашиглалтын явцад
10	Газрын хэвлий	Хаягдлын гадаад овоолго	Хаягдлын гадаад овоолгод баруун уурхайн овоолго уртаараа 4964 м, өргөнөөрөө 864 м, зүүн уурхайн овоолго уртаараа 2303 м, өргөнөөрөө 1086,6 м болж нийтдээ 679,2 га талбай дарагдана.	Хөрсний овоолгод 612.9~679.2 га талбай	Нөлөөллийн эрчим дунд	Хаягдал овоолгын нөхөн сэргээлт дуусах хүртэл
11		Уурхайн дэд бүтцийн барилга байгууламж баригдах	Төслийн хугацаанд нийт 306 га талбайд барилга байгууламжийг барьж газрын хэвлийд өөрчлөлт оруулна.	Өртөх талбайн хэмжээ 306 га	Нөлөөллийн эрчим дунд	Уурхайн ашиглалт болон нөхөн сэргээлт хийх хүртэл

Зураг 16. Овоот Толгой уурхайн объектийн нөлөөлөл



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Саусгоби сэндс ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг. Бид уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлж, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

2023 оны төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг удирдлага болгосон.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байх болно.

Бид 2023 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажиллана. Үүнд:

- Байгаль орчны удирдлагын тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд төслийн үйл ажиллагааны улмаас төсөл хэрэгжих нутгийн экосистемийн бүрэлдэхүүн хэсэг бүрт үзүүлэх байгаль орчны эрсдлүүдийн бүртгэл үнэлгээг хийж, тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний шат дараатай үйл ажиллагааны төлөвлөлт хийн, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Төсөл хэрэгжих нутагт байгаль орчны мэргэжлийн байгууллагаар орчны хяналт шинжилгээ, газрын доорхи усны хөндлөнгийн судалгааг мөн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Тус ажлуудыг зэргэлдээ орших уурхайнуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Байгаль орчинд нийлүүлэх хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжтой хог хаягдлын хэмжээг өмнөх оны хэмжээ буюу 70 орчим хувьд барих
- Нефтийн бүтээгдэхүүний асгаралт урьдчилан сэргийлж, бохирдсон хөрсийг эрүүлжүүлэх, саармагжуулах үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.
- Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ТЭРБУМ мод хөтөлбөрөөс манай байгууллага 15 сая мод тарих хариуцлагын гэрээнд нэгдсэн ба 2023 онд нийт 23,000 гаруй мод тарьж ургуулахаар төлөвлөж байна.
- Орон нутгийн байгаль хамгаалах малчдын нөхөрлөл, Төрийн болон Төрийн бус байгууллгатай хамтран ажиллаж хамтын ажлыг үргэлжлүүлнэ.
- Цэвэрлэх байгууламжаас гарсан усыг дахиг ашиглах ажлыг амжилттай хэрэгжүүлэх, үйл ажиллагааг тогтворжуулах, үргэлжлүүлнэ.
- Биет болон биет бус соёлыг хамгаалах ажлын хүрээнд нөлөөллийн сумдаас сонгон сумын иргэдийн дунд Ардын урлагын наадам зохион байгуулна.
- Байгаль орчны хуваарьт аудит хийлгэж мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

3.1. Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүнг удирдлага болгон ажиллана.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлс хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж, явцад нь хяналт тавин ажиллах болно.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг жил бүр шинэчилэн боловсруулж хэрэгжилтийг хангасаар ирсэн.

Овоот Толгой уурхайн БОННУ-ний нэмэлт тодотголын тайланд тусгагдсан байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөхдөө, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын хүрээнд гарсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулах зөвлөмжийн дагуу төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваан агаар, гадаргын ба газрын доорхи ус, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн төлөвлөсөн.

Саусгоби сэндс ХХК 2023 онд байгаль хамгаалах үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 17 ажил төлөвлөж сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 9 ажил, бууруулах арга хэмжээнд 8 төлөвлөсөн (Хүснэгт 7, 8-аас харна уу)

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил

№	Байгаль орчны бүрэлдэхүүн	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Төсөв	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
1	Агаар	Машин техникээс үүдэлтэй тоос босох агаарын чанарт нөлөөлөх	Олон салаа зам гаргахаас сэргийлэх, хурдны хязгаар тогтоох, Нүүрс тээврийн хатуу хучилттай замыг ашиглах	Нүүрс тээврийн хатуу хучилттай замын ашиглалтыг үргэлжлүүлнэ. Шороон замд хурдны хязгаарыг баримтална	Дотоод Үйл ажиллагаа	ХАБЭА,БОО НХ хэлтэс	МУ-ын болон Овоот Толгой уурхайн замын хөдөлгөөний дүрэм
2	Хөрсөн бүрхэвч	Тос тосолгоо, түлш хөрсөнд асгарч хөрсийг бохирдуулах	Асгаралтаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, техникийн үзлэг тогтмол хийх, Асгаралттай тэмцэх иж бүрдэл бүхий цэгийг сайжруулах	Нийт ажилчдад жил 1 удаа асгаралтаас урьдчилан сэргийлэх сургалтанд хамрагдсан байна. Хөдөлгөөнт тоног төхөөрөмжид өдөр бүр үзлэг хийх	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,БОО НХ, Засвар, Хангамжийн хэлтэс	Нефтийн бүтээгдэхүүн, тос тосолгооны материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх
3		Хөрс хуулагдах, түүний физик химийн шинж чанарт өөрчлөлт орох, биологийн цикл алдагдах	Зөвшөөрөл авсан газарт хөрс хуулалтын ажлыг явуулах, хяналт тогтмол тавих	Зөвшөөрөгдсөн газарт хөрс хуулалтын ажил явагдана. Шимт хөрсийг стандартын дагуу хуулагдаж зориулалтын талбайд хадгална	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,БО, ОНХ, Төлөвлөлтийн хэлтэс	Овоот Толгой уурхайн газар хөндөх журам Үржил шимт хөрсийг хуулах хадгалах ерөнхий шаардлага
4	Гадаргын болон гүний ус	Тоос тоосонцор нь тунадасжин бууж, гадаргын болон гүний ус бохирдуулах	Олон салаа зам гаргахгүй зөвхөн зөвшөөрөгдсөн замаар, хурдны хязгаартай машин техник зорчих	Хурдны хязгаарын замын тэмдэг байрлуулах	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,БОО НХ,ОХ	Овоот Толгой уурхайн замын хөдөлгөөний журам

№	Байгаль орчны бүрэлдэхүүн	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Төсөв	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
5		Химийн бодис материал шатах тослох материалын алдалт, асгаралтаас усны чанарт нөлөөлөх, бохирдох	Химийн бодис болон шатах, тослох материалыг хадгалалт ашиглалтанд тогтмол хяналт тавих	Химийн бодис материалын агуулах, ШТС-н агуулахад тогтмол үзлэг хийгдэх	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,БОО НХ, Засвар, Агуулах	Ажлын байрны үзлэг болон дотоод хяналт шалгалт
6	Ургамал	Тоосны дэгдэлт нь ургамлын навчны амсрын хаах, ургах чадварыг алдагдуулах	Хөдөлгөөнт техникийн улмаас тоос босож буй газарт усалгааг тогтмол хийх	Тоос дарах усалгаа тогтмол хийгдэх	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,БОО НХ, ОХ	Овоот Толгой уурхайн тоос дарах журам
7		Хөрс хуулах үед ургамал устах	Ургамлын хяналтын цэгүүдэд урт хугацааны ажиглалт хийх арга хэмжээ авах	Ургамлын хяналтын цэгүүдэд ажиглалтыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,БОО НХ хэлтэс	
8	Амьтан	Хогийн цэг дээр зэрлэг амьтад цуглах	Хогийн цэгийг бүрэн хашаажуулсан байна.	Хашааг засаж сайжруулсан байна	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,БОО НХ хэлтэс	Үзлэг болон дотоод хяналт шалгалт
9	Газрын хэвлий	Ил уурхай (ухагдсан нүх) Хаягдлын гадаад овоолго Дэд бүтэц барилга байгууламж	Зөвшөөрөгдсөн талбайд зөвшөөрлийн дагуу олборлолт явуулах, гадаад овоолго, барилга байгууламжийг барих үйл ажиллагаа явуулах	Зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явагдах	Дотоод үйл ажиллагаа	Бүх хэлтэс	Газрын тухай ашигт малтмалын тухай хууль
НИЙТ ДҮН					Бүгд дотоод үйл ажиллагаа гаар		

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах ажил

№	Байгаль орчны бүрэлдэхүүн	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Төсөв	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
1	Агаар	Тоосжилт үүсэх (хөрс хуулалт, тэсэлгээ, нүүрс олборлох, хаягдал хөрсийг овоолох, асгах, тээвэрлэх) хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөс	Усалгаа хийх, тээврийн хэрэгслийн хурдны хяналт тавих	Тоосжилтыг дарна	Дотоод Үйл ажиллагаа	ХАБЭА, БООН Х, ОХ	МУ-ын болон Овоот Толгой уурхайн замын хөдөлгөөний дүрэм
2	Хөрс	Тос тосолгоо, түлш хөрсөнд асгарч хөрсийг бохирдуулах	Асгаралт болсон тохиолдолд асгаралттай тэмцэх иж бүрдэл, цэгийг ашиглах Асгаралтаар бохирдсон хөрсийг цэвэрлэх саармагжуулах	Асгаралтай тэмцэх иж бүрдэл ашиглах, бохир хөрсийг бохирдсон хөрс хураах, эрүүлжүүлэх талбайд хураасан байна.	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА, БООН Х, ОХ, Засвар, Хангамжийн хэлтэс	Гидрокарбонь асгаралт тэмцэх журам
3		Хөрс хуулагдах, түүний физик химийн шинж чанарт өөрчлөлт орох Хөрсний биологийн цикл алдагдах	Хөрсний хяналтын цэгүүдэд чанарын шинжилгээг хийлгэх (ОХШХ) үр дүнд тулгуурлан хариу арга хэмжээ авах Эрүүл газар хөндөх тохиолдолд заавал шимт хөрсийг хуулах	Хөрсний чанарын шинжилгээ хийгдсэн байна Шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгална	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА, БООН Х, ОХ, Төлөвлөлтийн хэлтэс	Овоот Толгой уурхайн газар хөндөх журам Үржил шимт хөрсийг хуулах хадгалах ерөнхий шаардлага
4	Гадаргын болон гүний ус	Усны хэрэглээ ихсэх болон ус шавхалтын үйл ажиллагааны улмаас төслийн талбай, түүний	Уурхайн усны хэрэглээг оновчтой болгох зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах,	Ус ашиглалттай холбоотой сургалт орсон байна, тайлан гарсан байна.	10,0 сая	БООНХХэлтэс	Ажилчдын экологийн боловсролын дээшлүүлэх

№	Байгаль орчны бүрэлдэхүүн	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Төсөв	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
		орчмын газрын доорх усны түвшин буурах	Хөндлөнгийн мониторинг хийлгэх				сургалтын хөтөлбөр
5		Химийн бодис материал шатах тослох материалын алдалт, асгаралтаас усны чанарт нөлөөлөх, бохирдох	Асгаралт болсон торхиодол цаг алдалгүй арга хэмжээ авах Химийн бодис болон шатах, тослох материалыг хадгалалт ашиглалтанд тогтмол хяналт тавих, улирал тутам усны дээж шинжилгээнд өгөх	Асгаралт болсон тохиолдол арга хэмжээг яаралтай авсан байна. Шинжлгээний хариу авсан байх	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА, БООН Х, Засвар, ОХ Агуулах	Овоот Толгой уурхайн гидрокарбонь асгаралт
6	Ургамал	Тоосны дэгдэлт нь ургамлын навчны амсрын хаах, ургах чадварыг алдагдуулах	Тоосыг эх үүсвэр дээр нь дарах арга хэмжээг тогтмол авна	Тоос дарах усалгаа тогтмол хийгдэх	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА, БООН Х, ОХ	Овоот Толгой уурхайн тоос дарах журам
7	Амьтан	Хогийн цэг дээр зэрлэг амьтан цугларах	Ил задгай хоолны үлдэгдэл хаяхгүй байна	Хоолны үлдэгийг ил задгай хаяхгүй, гахайн аж ахуй эрхлэдэг иргэнд өгөх	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА, БООН Х хэлтэс	Хог хаягдлын тухай хууль
8	Газрын хэвлий	Ил уурхай (ухагдсан нүх) дэд бүтэц барилга байгуулаж	Зөвшөөрөгдсөн талбайд зөвшөөрлийн дагуу олборлолт явуулах, гадаад овоолго үүсгэх үйл ажиллагаа явуулах	Зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явагдах	Дотоод үйл ажиллагаа	Бүх хэлтэс	Газрын тухай ашигт малтмалын тухай хууль
НИЙТ ДҮН					10.0 сая		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай компани уурхай эхлэх явцад хөндөгдсөн ч ирээдүйд дахин олборлолтын үйл ажиллагаанд хамрагдахгүй талбайг ирээдүйн уурхайн хаалтын нөхөн сэргээлтэнд зориулан жил бүр /1-2 га талбай/ бага багаар сонгон авч техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг 2009 оноос эхлэсэн бөгөөд сүүлийн 12 жилийн хугацаанд уурхайд 147.84 га талбайд техникийн, 55.16 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж орон нутаг, улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Мөн 2021 онд Сэврэй суманд эвдэрч эзэнгүй орхигдсон 15 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Сэврэй сумын тамгын газарт хүлээлгэн өгөөд байна.

2023 оны тухайд Ерөнхийлөгчийн санаачилсан ТЭРБУМ мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг бие даасан хөтөлбөр болгож төсөв зохион байгуулалтыг тусад нь авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Мөн 2023 онд Гурвантэс сумын цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжын ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөв.

2023 онд уурхайн бүсэд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх талбай төлөвлөгдөөгүй болно.

Хүснэгт 9.Нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлын задаргаа

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал. төг	Нийт зардал. төг	Хэрэг жүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Хариуцлагатай уул уурхайн зарчимд тулгуурлан нутгийн унаган зүйлийг тарьж ургуулах, Суманд цэцэрлэгт	Орон нутгийн аж ахуй нэгжтэй хамтран гэрээ байгуулж сумын төвийн талбайд мод тарьж, ургуулах	ширхэг	3000-аас доошгүй	7600	22.800.000	2023 оны 4-11 сар	БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаал
2	хүрээлэн бий болгох ажилд үргэлжлүүлэн оролцох	Хашаан доторх тохижилтын ажил жижиг усан сан	ширхэг	1	10.000.000	10.000.000		
НИЙТ ТӨСӨВ						32.800.000		

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сүүлийн жилүүдэд Монгол улсад уул уурхай, түүнийг дагасан дэд бүтэц, бусад бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүд эрчимтэй хөгжихийн хирээр биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл нэмэгдсээр байна.

Нөлөөллийг бууруулах дарааллыг зохистой хэрэгжүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас холбогдох эрх зүйн орчныг бий болгон ажиллаж аж ахуйн нэгж байгууллагууд түүнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Саусгоби сэндс ХХК нь Овоот толгой уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байхаар төлөвлөн хамгааллын ажлыг шат дараатай хэрэгжүүлж байна. Үүний “ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2023 ОН

нэг нь биологийн олон янз байдлын амьдрах орчинг тэтгэх, тэдгээрийн үйлчилгээг дэмжих, судалгаа шинжилгээний ажилд үндэслэн хамгааллын менежментийн ажлыг зохион байгуулах ажил юм. Төслийн үйл ажиллагаа явуулж буй цөл, цөлөрхөг хээрийн бүс нутаг нь эрс тэс уур амьсгалтай, эмзэг экосистемд тооцогддог.


Экосистемийг бүрдүүлж буй биологийн олон янз байдлын зүйл дотор олон улс болон бүс нутгийн хэмжээнд ховор, ховордож болзошгүй, мөн популяцийн төлөв байдлын мэдээлэл дутмаг амьтан, ургамал олон бөгөөд тэдгээрийг хамгаалах, сөрөг нөлөөлөлд өртүүлэхгүй байлгах нь компаний байгаль орчны бодлогын нэг хэсэг юм.

Бид 2015 онд Овоот толгой уурхайн орчимд биологийн олон янз байдлын нарийвчилсан судалгаа хийж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах хэд хэдэн газрыг судалгааны үндсэн дээр тодорхойлон ажиллалаа.

Дээрх судалгааны үр дүнд Дүйцүүлэн хамгаалах газраар доорх газруудыг санал болгов. Үүнд:

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалахаар санал болгож буй газар

Д/д	Санал болгосон газрын нэр	Талбайн хэмжээ
1	Хуршуут, Наранбулаг, Дэлийн ус, Хөвдийн булаг	75023.88 га
2	Тост Тосон бумбын нуруу	103077.36 га
3	Сухантын булаг	8526 га



Зураг 17. Дүйцүүлэн хамгаалахаар санал болгож буй газар нутаг

Бид судалгааны ажлын үр дүнд санал болгосон газруудаас сум орон нутагт танилцуулж дүйцүүлэн хамгаалах ажлыг 2016-2020 онуудад Тост Тосон бумбын нуруунд гүйцэтгэсэн.

Тус газрыг сонгосон гол үндэслэл нь байршил нутгийн хувьд том хэмжээтэй, нэн ховор, ховор зүйл болох цоохор ирвэсийг хамгаалах, мөн идэш тэжээлийн холбоотой аргаль хонь, янгир ямаа зэрэг дэлхийд ховордсон зүйлүүдийг хамгаалах, тогтвортой өсөх нөхцлийг бүрдүүлэх, тархац нутаг, амьдрах орчныг хамгаалах явдал юм. Ховор ба ховордсон амьтдаас гадна харьцангуй өргөн тархалттай хуурай болон цөлжүү хээрийн амьтдын тодорхой тархац нутаг, амьдрах орчныг хамгаалахад чухал ач холбогдолтой.

2023 онд Биологийн олон янз байдлыг Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Тост, Тосон-Бумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаатай хамтран тодорхой нэг ажлыг санхүүжүүлэх, хамран ажиллахаар төлөвлөв. Тус ажилдаа орон нутгийн төр захиргааны байгууллагын саналыг үндэслэн хамтран ажиллах нь чухал юм.

Дүйцүүлэн хамгаалах ажилд манай компанийн зүгээс зарцуулагдах зардлын тоймыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар баталсан журмын холбогдох загварт туссан хүснэгтийн дагуу тусгав.

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал. төг	Нийт зардал. төг	Хэрэг жүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Дүйцүүлэн хамгаалах ажлыг жишиг байдлаар гүйцэтгэж бусад уурхайг манлайлах	ТТБумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаатай хамтран тодорхой нэг ажлыг санхүүжүүлэх	Тост, Тосон-Бумбын нурууны байгалийн нөөц газарт байгаль хамгааллын ажил хийгдсэн байх	-	42.000.000	42.000.000	2023 оны 8-12 сар	БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн тушаал

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Овоот Толгой уурхайн хувьд төслийн талбайд газар эзэмшигч, нутагладаг малчдаас бодит нүүлгэн суурьшуулалтанд хамруулсан бөгөөд цаашид газар ашиглалтыг нэмэгдүүлэхгүй байх, зайлшгүй тохиолдлоос бусад үед бодит нүүлгэн суурьшуулалтаас татгалзах бөгөөд 2023 онд нүүлгэн суурьшуулалтанд хамрагдах 6 өрх байна.

8.1 Төлөвлөгөөний хамрах хүрээ

Уурхайн ашиглалтын лиценц бүхий талбайн дотор болон ойролцоо нутагладаг газар эзэмшлийн гэрчилгээ бүхий өрхүүд хамрагдана.

8.2 Бүрэн хийгдсэн нүүлгэн суурьшуулалт

2008 онд уурхайн үйл ажиллагаа эхлэх үед уурхайн орчимд нутагладаг 2 өрх байсан бөгөөд эдгээр өрхүүдтэй харилцан тохиролцож гэрээ хийгдсэний үндсэн дээр 2013 онд уг өрхүүд өөрсдийн эзэмших гэрчилгээ бүхий газраас нүүлгэн 1 нь сумын төвд хашаа байшин бариулж суурьшсан ба нөгөөх нь өөр өвөлжөөн дээрээ суурьшсан. Тус өвөлжөөг тохижуулах, нүүлгэх зардлыг манай байгууллагаас хариуцан ажилласан.

8.3 Нүүлгэн суурьшуулалт хийгдэх төлөвлөгөө

Овоот Толгой төслийн хувьд төслийн талбайд газар эзэмшигч, нутагладаг малчдаас 5 өрхийг бодит нүүлгэн суурьшуулалтанд хамруулан өвс тэжээлийн хандив туслалцаа үзүүлэх, мөн ажлын байраар хангах тал дээр анхаарал хандуулах ба Гурвантэс суманд манай байгууллагаас баригдаж эхэлсэн 48-н айлын орон сууцыг 2023 онуудад барьж дуусгахаар төлөвлөж байгаа бөгөөд уг 6-н айлыг харилцан тохиролцсоны үндсэн дээр орон сууцжуулахаар төлөвлөөд байна.

Жич: Тус арга хэмжээнд төсөвлөгдөж байгаа нийт зардал нь /696 сая/ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт төсөвт тооцогдохгүй ба гадны хөрөнгө оруулалттай манай компанийн хувьд хэлтэс тус бүр өөрийн батлагдсан төсөвтэй байдаг тул манай орон нутгийн харилцааны нийгмийн хариуцлагын зардалд тусдаг. Мөн тус арга хэмжээ жил бүр гарах зардал бус нэг удаад шийдэгдээд дахин давтагдан гарахгүй зардал болно.

Хүснэгт 12. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал. төг	Нийт зардал. төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Нэр бүхий судалгаа хийгдсэн 6 өрх	6 өрхийн асуудлыг шийдэж Сумын төвд орон сууцжуулах	Зөвхөн харилцан тохиролцох гэрээ хийгдсэн айл, өрх	6	116.000.000	696.000.000	2023 оны турш	АМТ хуулийн 42.1 дэх хэсэг Хамтын ажиллагааны гэрээ

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЮНЕСКО-ийн конвенцыг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн түүхийн дурсгалууд, биет бус соёлын өвийн болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, судлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломж чиглэлийг эрэлхийлсэн сум орон нутгийн санаачлагуудыг дэмжин ажиллахаар төлөвлөж байна.

9.1 Олон нийтийн хөтөлбөр, биет бус өв

Өмнөговь аймгийн биет бус соёлын өв харьцангуй бага судлагдсан. Бид 2023 онд биет бус өвийн хүрээнд нөлөөллийн сумдаас сонгон нэг сумын нутгийн иргэдийн дунд ардын урлагын их наадам зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 13. Соёлын өвийг хамгаалах хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Биет бус өвийг хамгаалал	Ардын урлагын Их наадам	Сонгогдсон сумын ард иргэдийн дунд	4.0	4.0	2023 оны 4-р улирал	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэдэг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс, Байгаль орчин, орон нутгийн харилцааны хэлтэс уурхайд ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт түүний хаягдал болон сав баглаа боодлын устгалд хяналт тавьж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллана.

10.1 Химийн бодисын төрөл, хэмжээ

Овоот Толгой төслийн үйл ажиллагаанд 2018.01.18 - 2021.01.18 онд нийт 10 төрлийн химийн бодис, 6 төрлийн гидрокарбон бүхий найрлагатай химийн бүтээгдэхүүнийг /хольц/ Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл”-ийн дагуу авч ашиглаж байна.

10.2 Химийн бодис, материалаас үүсэж болох болзошгүй эрсдэл

Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанд ашиглагдах химийн бодис, материалуудын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгах үйл ажиллагааны явцад үүсэж болзошгүй аюул осол, эрсдлийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэн, аюул осол, эрсдэл тохиолдсон үед хариу арга хэмжээ авч дараах менежментийг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Тээвэрлэлт

Бид аюултай материал тээвэрлэхэд дараах шаардлагыг мөрдөн ажиллана. Үүнд:

- Гал унтраагч, галаас урьдчилан сэргийлэх материал, асгаралтаас урьдчилан сэргийлэх материал зэрэг нь Аюултай материалын зөвшөөрөлд тодорхойлсон хяналтын арга хэмжээний дагуу, тухайн тээвэрлэгдэж буй Аюултай материалтай таарч тохирсон байх
- Аюултай материалыг агуулж буй савыг тээвэрлэгдэхээс өмнө зохих ёсоор хамгаалсан байна
- Хор аюулын лавлах мэдээлэл, хортой, аюултай материалын тээвэрлэлтийн журманд заасны дагуу тухайн сав болон ачааны машиныг тэмдэглэж, анхааруулга болон зурагт хуудас наана
- Аюултай материалыг Монгол улсын стандартын дагуу Химийн бодисын бүртгэл хөтлөнө
- Саусгоби сэндс ХХК-ийн аюултай материалтай харьцах, тээвэрлэх байгууллагыг сонгон шалгаруулахдаа шаардлагад нийцэж байгаа эсэхийг нь баталгаажуулан ажиллана Аюултай материалын тээвэрлэлтийг тухайн тээвэрлэгч агуулахад хүлээлгэн өгөх хүртэл эрсдлийг хариуцан ажиллана
- Тухайн аюултай, хортой материалыг тээвэрлэгч байгууллагын аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан (цуваа, тээвэрлэлт хариуцсан ахлах ажилтан) нь тээвэрлэлтийг зөвшөөрөгдсөн замаар, замын хөдөлгөөний дүрэм журмын дагуу зохицуулан хөдөлгөөнт оролцож захиалагч талд хүлээлгэн өгнө

Хадгалалт

Бид төслийн үйл ажиллагаанд ашиглагддаг химийн бодисуудыг, материалын аюулгүй ажиллагааны хуудсанд заасан хадгалах гормийн хүрээнд гадаа болон дотор зориулалтын агуулах талбайд стандартын дагуу хадгалаж байна. Манай компани химийн бодис, материалын хадгалалтанд дараах шаардлага тавин ажиллана. Үүнд:

- Төслийн талбайд аливаа химийн бодисыг хадгалахдаа материалын аюулгүй ажиллагааны хуудсанд (MSDS)-д заасан шаардлагын дагуу бэлдсэн талбайд хадгална
- Тос тосолгооны материалын гормын бус хадгалалтын явцад асгаралт үүсч хөрс бохирдохоос урьдчилан сэргийлж зориулалтын цемент бетоноор цутгасан талбайд хадгалаж байна
- Шатамхай хийг гаднах агуулахад үйлдэрийн савтай нь цоож бүхий төмөр саравчтай торонд бэхлэх, бүх төрлийн дулаан үүсгүүр, оч, ил гал, нарны гэрлийн тусгалаас хол хадгална
- Аэрозолийн хаяг шошго тодорхой, гаргацтай мөн цохилт доргилтонд өртөхөөс хамгаалах орчинд хадгална



Зураг 18. Химийн бодис, материалын хадгалалт

Ашиглалт

Овоот Толгой уурхайд химийн бодис, материалыг ашиглахдаа MSDS-д тусгагдсан ашиглахтай холбоотой зааварчилгаа болон Овоот Толгой уурхай химийн бодис, материалтай харьцах, ашиглах журмын дагуу ажиллаж байна. Үүнд

- Химийн бодис, материалтай харьцах ажилтан бүр ашиглалтай холбоотой шаардлагатай бүрэн танилцсан байна
- Химийн бодис, материалтай харьцах хүн бүр Хөдөлмөр хамгааллын хэрэгслийг бүрэн хэрэглэсэн байна. Мөн материалын аюулгүй ажиллагааны хуудастай бүрэн танилцсаны дараа ашиглана.
- Ашиглалтын явцад шатах тослох материал, тос тосолгооны материал алдагдахаас үед асгаралттай тэмцэх материал бүхий иж бүрдлийг ашиглаж байна.

Устгал

Овоот Толгой уурхайд ашиглагдаж буй химийн бодис, материалын сав баглаа, боодол хаягдлыг зайлуулахдаа материалын аюулгүй ажиллагааны хуудсанд заасан, мөн уурхайн хог хаягдлын журмын дагуу сав баглаа боодлыг устгах хаях ажлыг гүйцэтгэнэ. Бид уурхайгаас гарч буй химийн бодис, материалын хаягдлыг дараах байдлаар устгалд оруулж зайлуулна. Үүнд:

- Нефть, нефтийн бүтээдэхүүний гаралтай хаягдал тос, тосолгоог зориулалтын саванд хурааж хаягдалт тос дахин боловсруулдаг үйлдвэрт нийлүүлэх
- Тос тосолгооны материалын торх, сав зэргийг бүрэн цэвэрлэж, дахин ашиглагдах хог хаягдлын нэр төрөлд багтаан, дахивар худалдан авдаг аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэн эдийн засгийн эргэлтэнд оруулах
- Зарим төрлийн аюултай хог хаягдлыг утаагүй шатаагч зууханд (Turbo burn) шатаах
- Бохирдсон хөрс хураах, цэвэршүүлэх талбайг 2010 онд байгуулж, тусгай журам гаргасан, төлөвлөгөөт онд тос, тосолгооны материал, бусад төрлийн бодисоор бохирдсон хөрсийг тусгаарлаж, механик аргаар цэвэршүүлэлт хийн ажиллана
- Зарим төрлийн аюултай хог хаягдлыг дахин ашиглагдах хог хаягдлын цэгт хураан хадгалах ба журмын дагуу нийлүүлэгчид буцаан өгөх
- Хог хаягдлын шатаах зориулалтын “Waste Incinerator WFS-100” загварын зуух авахаар төлөвлөсөн.



Зураг 19. Хаягдал тос, бохирдсон хөрс хураах цэвэршүүлэх талбай, зарим төрлийн хог хаягдал устгах шатаах зуух

Хүснэгт 14. Химийн бодис, материалаас үүсэж болох болзошгүй эрсдэл

№	Үе шат	Болзошгүй эрсдэл
1	Тээвэрлэлт	<ul style="list-style-type: none"> Тээвэрлэлтийн явцад байгалийн гамшигт үзэгдэл (хэт халалт, хэт хүйтрэлт, байгаль цаг уурын үзэгдэл), тоног төхөөрөмжийн гэнтийн эвдрэл гэмтэл, сав баглаа боодлын битүүмжлэл алдагдах зэргээс шалтгаалж шингэн болон хуурай бодис асгарах, хий ялгарах, шатаж дэлбэрэх түүний улмаас хүн болон экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлэх Химийн бодис, материалын Материалын аюулгүй ажиллагааны хуудсанд (MSDS) заасан зааврыг мөрдөөгүйгээс үүсэх аливаа эрсдэл
2	Хадгалалт	<ul style="list-style-type: none"> Химийн бодис материалыг зориулалтын бус агуулахад хадгалах явцад сав баглаа боодлын битүүмжлэл алдагдаж тос тосолгооны материалын асгаралт үүсэх, хөрс усыг бохирдуулах Шатамхай баллонтой хийг зориулалтын бус газар бэхэлгээгүй хадгалснаас үүдэж баллон унаж оч үүсэж гал гарах, тэсэрч дэлбэрэх Химийн бодис, материалыг зориулалтын бус агуулахад хадгалснаар сав баглаа боодлын чанар муудаж элэгдэх,цоорох асгаралт үүсэх Хадгалалтын горим алдагдсанаас агаарт хий дэгдэх, уурших, улмаар салхиар дамжин ойр орчмын агаарын чанарт сөргөөр нөлөөлөх Химийн бодис, материалын Материалын аюулгүй ажиллагааны хуудсанд (MSDS) заасан зааврыг мөрдөөгүйгээс үүсэх аливаа эрсдэл
3	Ашиглалт	<ul style="list-style-type: none"> Химийн бодисын сав баглаа боодол цоорох, хагарах гэмтэх Шатах тослох материал, тос тосолгооны материал алдагдах Хадгалалтын горим алдагдах буюу тусгайлан бэлтгээгүй талбайд шууд байрлуулах Химийн бодистой харьцаж байгаа ажилчдын мэдлэг, дадлага туршлага хангалтгүйгээс эсвэл анхаарал болгоомжгүйгээс ажлын хариуцлага алдах Химийн бодис, материалын Материалын аюулгүй ажиллагааны хуудсанд (MSDS) заасан зааврыг мөрдөөгүйгээс үүсэх аливаа эрсдэл
4	Устгал	<ul style="list-style-type: none"> Химийн бодис материалыг сав баглаа боодлыг ил задгай хаяснаар экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлэх Хаягдал шатаах үед хортой хий, ялангуяа удаан задардаг органик бохирдуулагчид агаарт ялгарах Химийн бодис, материалын Материалын аюулгүй ажиллагааны хуудсанд (MSDS) заасан зааврыг мөрдөөгүйгээс үүсэх аливаа эрсдэл

10.3 Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Уурхайн хэмжээнд химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах, сав баглаа боодлын устгалд онцгой хяналт тавьж ажилладаг.

Бид уурхайд ашиглагдаж буй химийн бодисуудтай харьцах, хадгалах, хог хаягдлыг устгахад дараах журмуудыг боловсруулан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн дагаж мөрдүүлэн ажиллаж байна. Эдгээрт:

- Уурхайн ахуйн хэрэгцээнд ашигладаг химийн бодисуудтай харьцах -SWP-067
- Гидрокарбон асгаралт-SWP-2
- Гидрокарбоны асгаралтаар бохирдсон хөрсийг хураах, цэвэршүүлэх талбайд тусгаарлах-EOP 4.6-4

Эдгээрийн дээр химийн бодистой холбоотой хууль тогтоомжийн биелэлтийг хангах, химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, хэрэглээг хянах, асгаралтаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд

- Байгууллагын бүхий л төвшинд асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт гарсан тохиолдолд шуурхай цэвэрлэх арга хэмжээ авах
- Нийт ажилчдын дунд асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн нөхцөлд хэрхэн ажиллах талаар системтэй мэдлэг олгох сургалтыг 3 сар дутамд тогтмол зохион байгуулах

10.4 Эрсдэл тохиолдох үед авах арга хэмжээ

Овоот Толгой уурхайд ашиглагдах химийн бодис материалаас үүсэх эрсдэл тохиолдож болзошгүй газруудыг тодорхойлвол. Үүнд:

Хүснэгт 15. Эрсдэл тохиолдож болох газрууд

№	Эрсдэл тохиолдож болох газрууд	Тохиолдож болох эрсдэл	Авах арга хэмжээ
1	Агуулах дотор	Химийн нэгдэл бүхий материалуудын гормын бус хадгалалтаас шалтгаалж асгаралт үүсэх, гал гарах, хүний эрүүл мэнд, экосистемд нөлөөлөх	Асгаралт болсон тохиолдолд нэн даруй асгаралттай тэмцэх иж бүрдлийг ашиглах Гал гарсан тохиолдолд галын хор ашиглах
2	Агуулах гадна	Гаднах агуулахад хадгалагдаж буй тос тосолгоны материалын сав баглаа боодол элэгдэж цоорох асгаралт үүсэх Баллонтой химийн бодисын хадгалалтын явцад хий алдагдах, гормын бус хадгалалтаас шалтгаалж гал гарах гэсэрч дэлбэрэх	Асгаралт болсон тохиолдолд нэн даруй асгаралттай тэмцэх иж бүрдлийг ашиглах Баллонтой бодисоос хий алдагдвал нэн даруй галын ахмадад мэдэгдэх
3	Засварын газар	Химийн бодис материалыг ашиглаж буй ажилтны мэдлэг, дадлага туршлага хангалтгүйгээс эсвэл анхаарал болгоомжгүйгээс ажлын хариуцлага алдаж асгаралт үүсэх, хий алдах г.м	Асгаралт болсон тохиолдолд нэн даруй асгаралттай тэмцэх иж бүрдлийг ашиглах Баллонтой бодисоос хий алдагдвал нэн даруй галын ахмадад мэдэгдэх Химийн бодис материал нүдэнд орсон тохиолдолд яаралтай цэвэр усаар угаах
4	Уурхай	Хөдөлгөөнт болон суурин тоног төхөөрөмжийн гэнтийн эвдрэл гэмтлээс шалтгаалж гидрокарбоны (түлш, тос тосолгоо г.м) асгаралт үүсэх	Асгаралт үүссэн тохиолдолд асгаралттай тэмцэх иж бүрдлийг ашиглах, асгаралтыг зогсоох арга хэмжээ авах
5	ШТГСтанц	Нефтийн бүтээгдэхүүнийг агуулах сав, болон шаланк цоорог асгаралт үүсэх, гал гарах	Бохирдсон хөрсийг бохир хөрс хураах, цэвэршүүлэх талбайруу нэн даруй зөөх
6	Хөдөлгөөнт техникийн паркийн талбай	Тоног төхөөрөмжийн гэнтийн эвдрэл гэмтлээс шалтгаалж гидрокарбоны асгаралт үүсэх	
7	Цэвэрлэх байгууламж	Цэвэрлэх байгууламжинд ашиглагдаж буй химийн бодис алдагдах, бохир ус асгарах г.м	Химийн бодис болон бохир ус асгарсан тохиолдолд нэн даруй цэвэрлэх арга хэмжээ авах



Зураг 20. Эрсдэл тохиолдох үед авах шаардлагатай хэрэгслүүд

Овоот Толгой уурхайн гидрокарбоны асгаралт

Овоот Толгой уурхайн олборлолтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хөдөлгөөнт болон суурин тоног төхөөрөмжийн гэнтийн эвдрэл гэмтэл, осол мөн тос, тосолгооны материал, түлш гэх мэт химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтын явцад үүсэж болох асгаралтаас урьдчилан сэргийлж ажилладаг.

Манай компаний байгаль орчны бодлогын нэг хэсэг нь үйл ажиллагаа явуулж буй лицензийн талбайд ямарч асгаралтгүй, хөрсний бохирдолгүй байхыг зорьж ажилладаг. Бид 2023 онд гидрокарбоны асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт гарсан тохиолдолд дараах арга хэмжээг авахаар төлөвлөөд байна. Үүнд:

- Техник, тоног төхөөрөмжинд гарч болох эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлж өдөр бүр техникийн үзлэг хийх
- Гэнтийн эвдрэл гэмтэл, аваар ослоос шалтгаалж асгаралт үүсэх тохиолдол асгаралтыг яаралтай цэвэрлэх, бохирдсон хөрсийг хөрс эрүүлжүүлэх талбайруу зөөх
- Асгаралттай тэмцэх иж бүрдэл, цэгийг үр ашигтай ашиглах сургалт зохион байгуулах
- Мөн асгаралттай холбоотой журмыг сайжруулж боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах



Зураг 21. Асгаралт үүссэн тохиолдолд хэрэглэх асгаралтай тэмцэх цэг, иж бүрдэл

10.5 Эрсдэл тохиолдсоны дараа авах арга хэмжээ, хяналт

Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг, амьтны аймаг төслийн химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгалтай үүдэлтэй нөлөөлөл өртөж болзошгүй ч энэ нь ихэнхдээ аюулгүй ажиллагааны заавар, журам, технологийн ашиглалтын горим алдагдах, байгалийн гамшигт үзэгдэл тохиолдох зэргээс шалтгаалан шууд болон дам байдлаар нөлөөлөх магадлалтай юм.

Бид Овоот Толгой уурхайд химийн бодис, материал алдагдаж байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд эрсдэл тохиолдсоны дараа авах арга хэмжээ, хяналтанд дараах ажлыг төлөвлөөд байна. Үүнд:

- Хөрс, усанд химийн бодис алдагдсан тохиолдолд тухайн бодис цаашаа тархан, хүрээгээ тэлэхээс сэргийлж тархалтыг хязгаарлах, арилгах арга хэмжээг яаралтай авах
- Гидрокарбоны асгаралт болсон тохиолдолд бохирдсон хөрсийг яаралтай бүрэн цэвэрлэж, бохирдсон хөрс хураах, цэвэршүүлэх талбайруу зөөх, хөрсийг эрүүлжүүлэх арга хэмжээ авах
- Асгаралтаас үүсэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах хариу арга хэмжээний дотоод журмыг мөрдөн ажиллах

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2023 ОН

- Химийн бодис асгарахад ажилчдын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон өөрийн аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар байнгын сургалтыг зохион байгуулах
- Химийн бодисын хаягдал, сав баглаа боодлыг дахин ашиглагдах хог хаягдлын төвлөрсөн цэг дээр байршуулах
- Овоот Толгой уурхайд химийн бодис материал алдагдахаас урьдчилан сэргийлж тогтмол хяналт тавих
- Химийн бодис, материалын хор аюулаас үүдэн бий болох эрсдэл, үр дагавар нь ноцтой тул урьдчилан сэргийлэх иж бүрэн арга хэмжээ авч, эрсдэлийн бууруулах, аюулгүй байдлыг хангах талаар бэлтгэл ажлыг зохих журмын дагуу хийнэ
- Ажилчин химийн бодис материалаар хордсон үед анхны тусламж үзүүлэх аргыг зааврын дагуу бүрэн хийх

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Саусгоби сэнде ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллаж байна.

Бид 2023 онд хог хаягдлын менежментийг сайжруулах 3R зарчмын хүрээнд дараах хэд хэдэн ажил төлөвлөж хэрэгжилтийг хангаж ажиллана. Үүнд:

- Анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлыг багасгах
- Хаягдал бүтээгдэхүүний дахин ашиглах
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх
- Уурхайн талбайд хог, хаягдлыг цуглуулах, тэвэрлэх, зөвшөөрөгдсөн цэгт дарж булаах ажлыг Гурвантэс сумын гэрээт компаниар гүйцэтгүүлэх
- Уурхайн үйл ажиллагаанаас гарч буй бүхий л төрлийн дахин ашиглагдах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж зориулалтын сав, тусгайлан бэлдсэн талбайд цуглуулж хураах
- Ангилан ялгаж цуглуулсан хог хаягдлыг хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хаяхгүйгээр цуглуулах, уурхайн тосгоноос зайлуулах зорилгоор хог хаягдлыг нэгдсэн цэгт эмх цэгцтэй төвлөрүүлэх
- Хог хаягдалтай холбоотой журмуудыг уурхайн нийт ажилчдад таниулах, хог хаягдлыг ангилан ялгах дадал соёлыг хэвшүүлэх сургалтыг тогтмол явуулах
- Ажлын байрны үзлэг шалгалтыг тогтмол хийж, журмуудын хэрэгжилтийг хангаж байгаа байдалд хяналт тавих
- Компанийн үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, хагас жилийн болон бүтэн жилийн тайлан гаргах
- Уурхайн хэмжээнд дахин ашиглагдах хог хаягдлыг ангилан ялгаж, нутгийн иргэдэд дагуу олгох



- Хоёрдогч түүхий эд дахин боловсруулдаг, бэлтгэдэг, цуглуулдаг, тээвэрлэдэг, зах зээлд нийлүүлдэг иргэд, байгууллага, үйлдвэрүүдэд худалдан борлуулах, нийлүүлэх замаар уурхайн тосгоноос зайлуулах ажлыг гүйцэтгэх

Тус төлөвлөгөөний хүрээнд дараах журмуудыг дагаж мөрдөнө.

- Овоот Толгой уурхайн хог хаягдлын журам
- Уурхайн тосгоноос дахин ашиглагдах хог хаягдлыг зайлуулах журам
- Овоот толгой уурхайн ахуйн хэрэгцээнд ашигладаг химийн бодис материалтай харьцах журам

Төслийн ажиллах хоног, ажиллах хүчний тоо болон тоног төхөөрөмжийн тооноос хамааран үүсэх боломжит хог хаягдлын хэмжээ, хадгалалт, нийлүүлэлт, устгалыг дараах хэлбэрээр ангилдаг. /Хүснэгт 16/.

Хүснэгт 16. Овоот Толгой уурхайн хог хаягдлын ангилан ялгалт

	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл	Код	Аюулын зэрэглэл	Жилд гарах нийт хэмжээ (шингэн- м ³ /жил) Хатуу-(тн/жил)	Дахин боловсруулах, үйлдвэрт нийлүүлэх	Хадгалах	Устгал	Иргэдэд олгох	Тайлбар
Ахуйн (шингэн-ш, хатуу-х)	Хуванцар сав								Борлуулах
	Шил								Нутгийн иргэдэд олгох
	Лааз								
	Сүү, жүүсний хайрцаг								
	Цаасан хайрцаг								Орон нутгийн иргэдэд олгох
	Уут шуудай								Орон нутгийн иргэдэд олгох
	Ахуйн хог хаягдал								
Ш	Хоолны хаягдал								Гахайн аж ахуй эрхэлдэг иргэнд олгох
Үйлвэрийн (шингэн-ш, хатуу-х)	Хаягдал дугуй жижиг								
	Хаягдал дугуй том								
	Хаягдал мод								Орон нутгийн иргэдэд олгох
	Х	Үнс							
	Гэрлийн шил								
	Төмрийн хаягдал								Борлуулах
	Агаар шүүгч фильтр								Орон нутгийн иргэдэд олгох
Ш	Бохир ус								Дахин ашиглах
Аюултай хортгой (шингэн-ш, хатуу-х)	Аккумулятор								
	Тостой даавуу								Устгалд оруулах
	Тостой торх, сав								
	Х	Тосны хаягдал фильтр							Борлуулах
	Химийн бодис материал сав баглаа боодол								
	Ш	Хаягдал тос							

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Бид Овоот Толгой нүүрсний уурхайн төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ий тайлан, БОХТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг шалгах, үнэлэх ажлын хэсэг 2015 оны дүгнэлтэд “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийг зэргэлдээ орших уурхайнууд хамтран зохион байгуулахыг тусгасан байдаг.

Иймд Нарийн сухайтын нүүрсний бүлэг ордод орших уурхайнууд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх шаардлага бий болж 2016 оноос Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 7-дахь жилдээ хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 2023 онд уурхайнууд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх болно.


Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын задргаа

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналты цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Агаар	Өмнөговь аймаг Гурвантэс сум Бага овоо 5-р баг Нарийн Сухайтын бүлэг орд Саусгоби сэндс ХХК талбай	Жилд нэг удаа 2023.11 сар	18 цэгээс	81000	1468000	Ажилчидын цалин, хээрийн судалгаа, тайлан боловсруулах зардал ороогүй болно	MNS 3384:1984 MNS 4585:2016
2	Хөрс			19 цэгээс	80000	1520000		MNS 3298:1990 MNS 3310:1991
3	Гадаргын ус			5 цэгээс	94800	474000		MNS ISO 5667-6-2001 MNS ISO 5667-10-2001 MNS 4586:1998
4	Газрын доорх ус			8 цэгээс	97000	776000		MNS 900:2018
5	Ургамлан бүрхэвч			15 цэгээс	60000	900000		Друде (1913)-гийн нүдэн баримжааны арга. Ургамлын зүйлийг Грубов (1982)-ын таних бичиг-ээр тодорхойлно. Ургамлан нөмрөгийн талхагдлын зэргийг Гунин, Востокова 7(1989) нарын аргаар тус тус тодорхойлох
6	Амьтны аймаг			18 цэгээс	59000	1062000		Нүдээр ажиглагдсан амьтдыг бүртгэж тэмдэглэхээс гадна ул мөрөөр(баас, мөр) зарим амьтдыг бүртгэв. Нэг цэгээс нөгөө цэг хүртэл замналаар явж тааралдсан амьтдыг бүртгэн байршлыг тэмдэглэсэн.
7	НИЙТ ЗАРДАЛ					6,200,000	-	

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Саусгоби сэндс компани нь Монгол улсын байгаль орчинтой холбоотой хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах, нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэх хамгаалах, төсөл хэрэгжих орчинд бий болох болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянаж, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, орон нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчныг хамгаалж, уг үйл ажиллагаанд манлайлагч байхыг зорьж ажилладаг болно.

Бид 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд доорх удирдлага зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажиллах болно. Үүнд



Бид Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, түүний дагуу хариу арга хэмжээ авах мөн нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчныг хамгаалах, хамтран ажиллах зорилт тавьсан.

Ковид-19 цар тахлын улмаас уурхайн олборлолтын үйл ажиллагаа нилээд саатаж 2023 оноос үйл ажиллагаа хэвийн явж байна. Бид өнгөрсөн оны БОМТ хэрэгжилт түүнээс гарсан дүгнэлт зөвлөмж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн төлөвлөсөн. Энэ жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 468 сая төгрөг төсөвлөөд байна.

Хүснэгт 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтын хүрээнд 2023 онд хийгдэх ажлууд

№	Хамрах хүрээ	Төлөвлөлт Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах журам, хууль стандарт
1	Холбогдох төлөвлөгөөг боловсруулж батлуулах, Бусад байгаль орчны гэрээт ажил	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулах	2-р улирал	Дотоод. Ү.А	БООН хэлтэс	Межментийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-05 тушаал
2		Овоот толгой уурхайн БОННУ-д нэмэлт тодотгол хийх	2-р улирал	46.0	БООН хэлтэс, гэрээт мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэх	Нэмэлт тодотгол хийгдсэн байна	БОННУ тухай хууль
3		Шатахуун түгээх станцын Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа хийлгэх	4-р улирал	15.0		ГТБЧУБ баталгаа хийгдсэн байна	Газрын тухай хууль
4		Хуулийн дагуу Байгаль орчны аудит хийлгэх	2, 3-р улирал	20.0		Аудитын тайлан	Байгаль орчны тухай хууль
5	Биологийн олон янз байдал	Уурхайн талбай доторх зэрлэг амьтанг усаар ундаалах нөхцлийг бүрдүүлж боломжтой газар жижиг цөөрөм хийж усаар дүүргэж байх	2, 3-р улирал	7.0	БООН хэлтэс	Зэрлэг амьтны амьдрах орчинд Биотехникийн арга хэмжээг авсан байна	Амьтны тухай хууль
6		Тост, Тосон-Бумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллаж захиргааны байр барих ажилд дэмжлэн үзүүлэх	3, 4-р улирал	60 сая	БООН хэлтэс	Хамгааллын менежментийн үйл ажиллагаа сайжрах	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал
7	Нөхөн сэргээлт	Өмнөговь аймаг болон Гурвантэс сумаас өгөх чиглэлийн дагуу хуваарьт газруудад мод тарих ажлыг гүйцэтгэх	3-р улирал	90 сая	БООН хэлтэс	Төгөл байгуулах ажлыг эхэлж 200.000 ширхэгээс доошгүй Мод тарьж ургуулсан байна	Ерөнхийлөгч болон БОАЖЯ-наас өгсөн бодлого, чиглэл
8	Химийн бодис	Химийн бодис материалын ашиглалт тусгай зөвшөөрөл сунгах	4-р улиралд	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Зөвшөөрөл сунгасан байх	БОАЖЯ-наас өгсөн бодлого, чиглэл
9	Газар	Газрын эвдэрлийг бага байлгах, байнга бүртгэлжүүлэх	Тухай бүр	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Бүртгэл хийгдсэн байна	

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2023 ОН

№	Хамрах хүрээ	Төлөвлөлт Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах журам, хууль стандарт
10	Хөрсний эвдрэл гэмтэл, бохирдлоос сэргийлэх, хөрсний хяналт тавих	Хөрсний бохирдол гидрокарбоны асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, тогтмол хяналт тавих	Тухай бүр	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Арга хэмжээ авч тайланг гарсан байна	Газрын тухай хууль, бохирдлоос сэргийлэх
11		Бохирдсон хөрсийг цэвэршүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх /бууц холих/	3, 4-р улиралд	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Бууц хольсон байна	Овоот Толгой уурхайн бохир хөрсийг цэвэршүүлэх талбайд хураах
12	Усны менежменти	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	2-р улирал	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Дүгнэлт гарсан байна	Усны тухай хууль
13		Ус ашиглах гэрээг холбогдох төрийн байгууллагатай хийх	2-р улирал	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Гэрээ хийгдсэн байна	
		Бохир усны дүгнэлт гаргуулах					
14		Усны ашигласны төлбөрийг сар бүр төлөх	Тухай бүр	Нэхэмж лэхээр	БООН хэлтэс	Төлбөрийн тухай бүр төлсөн байна	
15		Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар мониторингийн судалгаа хийлгэх, тайлагнах	3, 4-р улирал	10.0	БООН хэлтэс	Усны дээж болон бусад бүх судалгаа хийсэн байх	
16		Сар бүрийн 25 нд худгийн тоолуурын заалт баталгаажуулаж акт үйлдэх	Сар бүр	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Гурвантэс сумын байгаль хамгаалагчтай актаар хүлээлцсэн байна	
17		Цэвэрлэх байгууламжаас гарсан усыг дахин ашиглах, чанарт хяналт тавина	Жилийн турш	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Усны чанарт тогтмол хяналт тавина	
18	Агаарын чанарын хяналт	Тоосыг эх үүсвэр дээр нь дарах арга хэмжээг авч тогтмол усалгааг хийх	Тухай бүр	10.0	БООН хэлтэс	Усалгаа хийгдэж тоосжилт буурна	Агаарын чанарын тухай хууль

№	Хамрах хүрээ	Төлөвлөлт Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах журам, хууль стандарт
19	Хог хаягдлын менежмент	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын ангилан ялгалтыг хэвийн үргэлжүүлнэ	Жилийн турш	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Ангилан ялгалт хийх ажил үргэлжилнэ	Хог хаягдлын тухай хууль Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
20		Дахин ашиглагдах хог хаягдлын хэмжээг өмнөх жилийнхээс доош оруулахгүй байх	Тухай бүр	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Дахин ашиглагдах хог хаягдал өмнөх жилийнхээс багагүй байна.	Хог хаягдлын тухай хууль Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
21		Дахивар худалдан авдаг аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах	Тухай бүр	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Хаягдал тос, тосны фильтр зарсан байна	
22		Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжиж хог хаягдал тээвэрлэх, цуглуулах үйл ажиллагааг гүйцэтгүүлэх	Жилийн турш	119.0	“Хайртын босго” ХХК	Хог тээвэрлэлтийн үйл ажиллагаа хэвийн явагдана.	
23	Орчны хяналт мониторинг	Гадаргын болон гүний усны мониторинг	3, 4-р	2.0	БООН хэлтэс	Холбогдох мониторинг судалгааны ажил хийгдэж тайланг гарсан байна	
24		Уурхай орчмын ургамлын мониторинг	3-р улирал	2.0	БООН хэлтэс		
25		Уурхай орчмын зэрлэг амьтны мониторинг	3, 4-р улирал	2.0	БООН хэлтэс		
26		Хөндлөнгийн мониторинг хяналт шинжилгээ	3, 4-р улирал	6.2 сая	БООН хэлтэс болон зэргэлдээ бусад уурхайнууд	Байгаль очрын менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам	
	Тайлан мэдээ, хяналт шалгалт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжилтэн жилийн тайлан мэдээ боловсруулах	4-р улирал	Дотоод Ү.А	БООН хэлтэс	Тайлангууд гарсан байна	Байгаль очрын менежментийн төлөвлөгөө
		Усны ашиглалтын тайлан	4-р улирал				

№	Хамрах хүрээ	Төлөвлөлт Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах журам, хууль стандарт
		Орчны хяналт шинжилгээ мониторингийн ажлын жилийн тайлан	4-р улирал				боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
		Биологийн олон янз байдлын тайлан боловсруулах	4-р улирал				
		Нөхөн сэргээлт, газар ашиглалтын тайлан	4-р улирал				
		Дотоот хяналтын шалгалтын ажлын тайлан	4-р улирал				
		Хог хаягдлын тайлан	4-р улирал				
		Химийн бодис, материалын тайлан					

14. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛИЙН ТАЛААР ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ

Саусгоби Сэндс ХХК Овоот Толгой уурхайг ашиглах явцад байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс зайлс хийх, бууруулах, нөхөн сэргээх арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажилладаг. Бид 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг талуудад дараах хуваарын дагуу тайлагнах төлөвлөгөөтэй байна. Хүснэгт 20-оос харна уу

Хүснэгт 20. Овоот Толгой уурхайн 2023 онд БОМТ түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Цахим мэдээллийн санд тайланг байршуулах	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жилийн эцэст	Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах зүйлс	Улаанбаатар хот
Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жилийн эцэст	Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах, анхаарах зүйлс, Хамтран ажиллах	Өмнөговь аймаг
Гурвантэс сумын Засаг дарга	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жилийн эцэст	Хамтран ажиллах	Гурвантэс сум
Бага овоо багийн иргэдэд	Тайлангийн товч хураангуй	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр товч илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зураг, шинжилгээ, судалгааны үр дүнгээр баталгаажсан байна	Жилийн эцэст	Хамтран ажиллах	Бага овоо баг

ХАВСРАЛТ